

**ТӨРИЙН БАЙГУУЛАЛТЫН БАЙНГЫН ХОРООНЫ  
ХУРАЛДААНЫ ТЭМДЭГЛЭЛИЙН АГУУЛГА  
2024 оны 01 дүгээр сарын 16-ны өдөр, Мягмар гараг**

*Хуралдааны тэмдэглэлийн агуулга*

<i>Хуралдааны товч тэмдэглэл:</i>	1-8
<i>Хуралдааны дэлгэрэнгүй тэмдэглэл:</i>	9-24

---

<i>1. “Төрийн байгууллагуудыг бүсчлэн байршуулах тухай” Улсын Их Хурлын тогтоолын төсөл /Засгийн газар 2024.01.05-ны өдөр өргөн мэдүүлсэн, анхны хэлэлцүүлэг/</i>	7-8
<i>2. Монголын үндэсний олон нийтийн радио, телевизийн Үндэсний зөвлөлийн гишүүнийг томилох, чөлөөлөх тухай асуудал</i>	8-11
<i>3. Төрийн албаны зөвлөлийн гишүүнийг томилох, чөлөөлөх тухай асуудал</i>	11-16
<i>4. “Монгол Улсын Их Хурлын 2024 оны хаврын ээлжит чуулганаар хэлэлцэх асуудлын тухай” Улсын Их Хурлын тогтоолын төсөл</i>	16-18
<i>5. “Хянан шалгах түр хороо байгуулах тухай” Улсын Их Хурлын тогтоолын төсөл</i>	18-23
<i>6. Байнгын хорооны тогтоолын төсөл /Ажлын хэсгийн бүрэлдэхүүнд өөрчлөлт оруулах тухай/</i>	23
<i>7. Байнгын хорооны тогтоолын төсөл /Ажлын хэсэг байгуулах тухай/</i>	23-24

**Монгол Улсын Их Хурлын 2023 оны намрын ээлжит чуулганы  
Төрийн байгуулалтын байнгын хорооны  
2024 оны 01 дүгээр сарын 16-ны өдөр /Мягмар гараг/-ийн  
хуралдааны товч тэмдэглэл**

Төрийн байгуулалтын байнгын хорооны дарга Н.Энхболд ирц, хэлэлцэх асуудлын дарааллыг танилцуулж, хуралдааныг даргалав.

Хуралдаанд ирвэл зохих 19 гишүүнээс 11 гишүүн хүрэлцэн ирж, 57.9 хувийн ирцтэйгээр хуралдаан 15 цаг 55 минутад Төрийн ордны “Жанжин Д.Сүхбаатар” танхимд эхлэв.

Чөлөөтэй: Ё.Баатарбилэг, С.Бямбацогт, Г.Ганболд, Л.Оюун-Эрдэнэ, Ж.Эрдэнэбат.

**Нэг. “Төрийн байгууллагуудыг бүсчлэн байршуулах тухай” Улсын Их Хурлын тогтоолын төсөл /Засгийн газар 2024.01.05-ны өдөр өргөн мэдүүлсэн, анхны хэлэлцүүлэг/**

Хэлэлцэж буй асуудалтай холбогдуулан Улсын Их Хурлын гишүүн, Монгол Улсын Шадар сайд С.Амарсайхан, Засгийн газрын Хэрэг эрхлэх газрын Тэргүүн дэд дарга Б.Ганбат, мөн газрын Хууль, эрх зүйн газрын дарга Ч.Дондогмаа, Засгийн газрын референт О.Дөлгөөнтуул, Эдийн засаг, хөгжлийн яамны Бүс нутаг, аж үйлдвэрийн бодлогын газрын дарга Д.Эрдэнэбаяр нар оролцов.

Хуралдаанд Улсын Их Хурлын Тамгын газрын Хууль, эрх зүйн газрын Зөвлөхүүдийн албаны зөвлөх Ц.Баянмөнх, С.Дунжидмаа, Байнгын хорооны асуудал хариуцсан хэлтсийн дарга Г.Агар-Эрдэнэ, мөн хэлтсийн Төрийн байгуулалтын байнгын хороо хариуцсан ахлах зөвлөх Б.Хатантуул, референт Э.Баттогтох, мөн хэлтсийн референт А.Наранцэцэг нар байлцав.

*Зарчмын зөрүүтэй саналын томъёоллоор санал хураалт явуулав.*

**Н.Энхболд:** Улсын Их Хурлын гишүүн Н.Энхболдын гаргасан, Төслийн 1 дэх заалтын 1 дэх дэд заалтын “арга хэмжээ авах” гэснийг “талаарх бодлогыг боловсруулах” гэж өөрчлөх гэсэн саналыг дэмжье гэсэн санал хураалт явуулья.

Зөвшөөрсөн: 7  
Татгалзсан: 6  
Бүгд: 13  
53.8 хувийн саналаар дэмжигдлээ.

**Н.Энхболд:** Улсын Их Хурлын гишүүн Н.Энхболдын гаргасан, Төслийн 1 дэх заалтын 2 дахь дэд заалтын “шаардлагатай бол” гэснийг хасах гэсэн санал хураалт явуулья.

Зөвшөөрсөн: 7  
Татгалзсан: 5  
Бүгд: 12  
58.3 хувийн саналаар дэмжигдлээ.

Зарчмын зөрүүтэй саналын томьёоллоор санал хурааж дууслаа.

Байнгын хорооноос гарах санал, дүгнэлтийг Улсын Их Хурлын гишүүн Д.Сарангэрэл Улсын Их Хурлын чуулганы нэгдсэн хуралдаанд танилцуулахаар тогтов.

*Уг асуудлыг 16 цаг 06 минутад хэлэлцэж дуусав.*

**Хоёр. Монголын үндэсний олон нийтийн радио, телевизийн Үндэсний зөвлөлийн гишүүнийг томилох, чөлөөлөх тухай асуудал**

Хэлэлцэж буй асуудалтай холбогдуулан Монголын үндэсний олон нийтийн радио, телевизийн Үндэсний зөвлөлийн гишүүнд нэр дэвшигч Н.Нанзаддорж оролцов.

Хуралдаанд Улсын Их Хурлын Тамгын газрын Хууль, эрх зүйн газрын Зөвлөхүүдийн албаны зөвлөх Ц.Баянмөнх, С.Дунжидмаа, Байнгын хорооны асуудал хариуцсан хэлтсийн дарга Г.Агар-Эрдэнэ, мөн хэлтсийн Төрийн байгуулалтын байнгын хороо хариуцсан ахлах зөвлөх Б.Хатантуул, референт Э.Баттогтох, мөн хэлтсийн референт А.Наранцэцэг нар байлцав.

Нэр дэвшигчийн талаарх сонсголын тайланг Улсын Их Хурлын гишүүн Д.Сарангэрэл танилцуулав.

Тайлантай холбогдуулан Улсын Их Хурлын гишүүдээс асуулт, санал гараагүй болно.

**Н.Энхболд:** Дуламрагчаагийн Жавзандоржийг Монголын үндэсний олон нийтийн радио, телевизийн Үндэсний зөвлөлийн гишүүнээс чөлөөлөх саналыг дэмжье гэсэн санал хураалт явуулья.

Зөвшөөрсөн: 8  
Татгалзсан: 4  
Бүгд: 12  
66.7 хувийн саналаар санал дэмжигдлээ.

*Нэр дэвшигчийг томилох саналыг нууц санал хураалтаар явуулав.*

**Н.Энхболд:** Ноовойн Нанзаддоржийг Монголын үндэсний олон нийтийн радио, телевизийн Үндэсний зөвлөлийн гишүүнээр томилох саналыг дэмжье гэсэн санал хураалт явуулья.

Зөвшөөрсөн: 8  
Татгалзсан: 4  
Бүгд: 12  
66.7 хувийн саналаар санал дэмжигдлээ.

Байнгын хорооны дарга Н.Энхболд “Монголын үндэсний олон нийтийн радио, телевизийн Үндэсний зөвлөлийн гишүүнээр томилох, гишүүнээс чөлөөлөх тухай” Улсын Их Хурлын тогтоолын төслийг уншиж танилцуулав.

Байнгын хорооноос гарах санал, дүгнэлтийг Улсын Их Хурлын гишүүн Д.Сарангэрэл Улсын Их Хурлын чуулганы нэгдсэн хуралдаанд танилцуулахаар тогтов.

*Уг асуудлыг 16 цаг 14 минутад хэлэлцэж дуусав.*

***Гурав. Төрийн албаны зөвлөлийн гишүүнийг томилох, чөлөөлөх тухай асуудал***

Хэлэлцэж буй асуудалтай холбогдуулан Төрийн албаны зөвлөлийн гишүүнд нэр дэвшигч Б.Пүрэвдагва, Л.Цэдэвсүрэн нар оролцов.

Хуралдаанд Улсын Их Хурлын Тамгын газрын Хууль, эрх зүйн газрын Зөвлөхүүдийн албаны зөвлөх Г.Анар-Эрдэнэ, С.Дунжидмаа, Байнгын хорооны асуудал хариуцсан хэлтсийн дарга Г.Агар-Эрдэнэ, мөн хэлтсийн Төрийн байгуулалтын байнгын хороо хариуцсан ахлах зөвлөх Б.Хатантуул, референт Э.Баттогтох, мөн хэлтсийн ахлах мэргэжилтэн Б.Галсанбат нар байлцав.

Нэр дэвшигчийн талаарх сонсголын тайланг Улсын Их Хурлын гишүүн Ц.Мөнхцэцэг танилцуулав.

Тайлантай холбогдуулан Улсын Их Хурлын гишүүн Ц.Мөнх-Оргил, Н.Энхболд, Д.Тогтохсүрэн, Б.Пүрэвдорж нар үг хэлэв.

**Н.Энхболд:** Балданы Баатарзоригийг Төрийн албаны зөвлөлийн орон тооны гишүүнээс чөлөөлөх саналыг дэмжье гэсэн санал хураалт явуулъя.

Зөвшөөрсөн: 7  
Татгалзсан: 5  
Бүгд: 12  
58.3 хувийн саналаар санал дэмжигдлээ.

**Н.Энхболд:** Самданы Цэдэндамбыг Төрийн албаны зөвлөлийн орон тооны гишүүнээс чөлөөлөх саналыг дэмжье гэсэн санал хураалт явуулъя.

Зөвшөөрсөн: 8  
Татгалзсан: 4  
Бүгд: 12  
66.7 хувийн саналаар санал дэмжигдлээ.

**Н.Энхболд:** Баярын Пүрэвдагвыг Төрийн албаны зөвлөлийн орон тооны гишүүнээр томилох саналыг дэмжье гэсэн санал хураалт явуулья.

Зөвшөөрсөн: 7  
Татгалзсан: 5  
Бүгд: 12  
58.3 хувийн саналаар санал дэмжигдлээ.

**Н.Энхболд:** Лхагвын Цэдэвсүрэнг Төрийн албаны зөвлөлийн орон тооны гишүүнээр томилох саналыг дэмжье гэсэн санал хураалт явуулья.

Зөвшөөрсөн: 7  
Татгалзсан: 5  
Бүгд: 12  
58.3 хувийн саналаар санал дэмжигдлээ.

Байнгын хорооны дарга Н.Энхболд “Төрийн албаны зөвлөлийн орон тооны гишүүнийг томилох, гишүүнээс чөлөөлөх тухай” Улсын Их Хурлын тогтоолын төслийг уншиж танилцуулав.

Байнгын хорооноос гарах санал, дүгнэлтийг Улсын Их Хурлын гишүүн Ц.Мөнхцэцэг Улсын Их Хурлын чуулганы нэгдсэн хуралдаанд танилцуулахаар тогтов.

*Уг асуудлыг 16 цаг 36 минутад хэлэлцэж дуусав.*

**Дөрөв.** “Монгол Улсын Их Хурлын 2024 оны хаврын ээлжит чуулганаар хэлэлцэх асуудлын тухай” Улсын Их Хурлын тогтоолын төсөл

Хуралдаанд Улсын Их Хурлын Тамгын газрын Хууль, эрх зүйн газрын Зөвлөхүүдийн албаны зөвлөх Г.Анар-Эрдэнэ, Д.Нямбаяр, Байнгын хорооны асуудал хариуцсан хэлтсийн дарга Г.Агар-Эрдэнэ, мөн хэлтсийн Төрийн байгуулалтын байнгын хороо хариуцсан ахлах зөвлөх Б.Хатантуул, референт Э.Баттогтох нар байлцав.

Улсын Их Хурлын тогтоолын төслийн талаар Байнгын хорооны дарга Н.Энхболд танилцуулав.

Тогтоолын төсөлтэй холбогдуулан Улсын Их Хурлын гишүүдээс асуулт, санал гараагүй болно.

**Н.Энхболд:** “Монгол Улсын Их Хурлын 2024 оны хаврын ээлжит чуулганаар хэлэлцэх асуудлын тухай” Улсын Их Хурлын тогтоолын төслийг чуулганы нэгдсэн хуралдаанд оруулж батлуулах нь зүйтэй гэсэн санал хураалт явуулья.

Зөвшөөрсөн: 9  
Татгалзсан: 3  
Бүгд: 12  
75.0 хувийн саналаар дэмжигдлээ.

Байнгын хорооноос гарах санал, дүгнэлтийг Улсын Их Хурлын гишүүн Н.Энхболд Улсын Их Хурлын чуулганы нэгдсэн хуралдаанд танилцуулахаар тогтов.

*Уг асуудлыг 16 цаг 43 минутад хэлэлцэж дуусав.*

**Тав. “Хянан шалгах түр хороо байгуулах тухай” Улсын Их Хурлын тогтоолын төсөл**

Хуралдаанд Улсын Их Хурлын Тамгын газрын Хууль, эрх зүйн газрын Зөвлөхүүдийн албаны зөвлөх Г.Анар-Эрдэнэ, С.Дунжидмаа, Байнгын хорооны асуудал хариуцсан хэлтсийн дарга Г.Агар-Эрдэнэ, мөн хэлтсийн Төрийн байгуулалтын байнгын хороо хариуцсан ахлах зөвлөх Б.Хатантуул, референт Э.Баттогтох, мөн хэлтсийн референт А.Наранцэцэг нар байлцав.

Төслийн талаарх танилцуулгыг Улсын Их Хурлын гишүүн Ж.Батсуурь танилцуулав.

Байнгын хорооны дарга Н.Энхболд Нийслэлийн Засаг дарга бөгөөд Улаанбаатар хотын захирагч асан Д.Сумъяабазараас ирүүлсэн албан бичиг болон Улсын Их Хурлын тогтоолын төслийн талаар танилцуулав.

Улсын Их Хурлын гишүүн Ц.Мөнхцэцэгийн тавьсан асуултад Улсын Их Хурлын гишүүн Ж.Батсуурь хариулж, тайлбар хийв.

**Н.Энхболд:** ““Хянан шалгах түр хороо байгуулах тухай” Улсын Их Хурлын тогтоолын төслийг чуулганы нэгдсэн хуралдаанаар оруулж батлуулах нь зүйтэй гэсэн саналыг дэмжье гэсэн санал хураалт явуулъя.

Зөвшөөрсөн: 9  
Татгалзсан: 3  
Бүгд: 12  
75.0 хувийн саналаар дэмжигдлээ.

Байнгын хорооноос гарах санал, дүгнэлтийг Улсын Их Хурлын гишүүн А.Адьяасүрэн Улсын Их Хурлын чуулганы нэгдсэн хуралдаанд танилцуулахаар тогтов.

*Уг асуудлыг 17 цаг 07 минутад хэлэлцэж дуусав.*

**Зургаа. Байнгын хорооны тогтоолын төсөл /Ажлын хэсгийн бүрэлдэхүүнд өөрчлөлт оруулах тухай/**

Хуралдаанд Улсын Их Хурлын Тамгын газрын Хууль, эрх зүйн газрын Байнгын хорооны асуудал хариуцсан хэлтсийн дарга Г.Агар-Эрдэнэ, мөн хэлтсийн Төрийн байгуулалтын байнгын хороо хариуцсан ахлах зөвлөх Б.Хатантуул, референт Э.Баттогтох нар байлцав.

Байнгын хорооны дарга Н.Энхболд тогтоолын төслийн талаар танилцуулав.

Тогтоолын төсөлтэй холбогдуулан Улсын Их Хурлын гишүүдээс асуулт, санал гараагүй болно.

**Н.Энхболд:** “Ажлын хэсгийн бүрэлдэхүүнд өөрчлөлт оруулах тухай” Байнгын хорооны тогтоолын төслийг батлах санал хураалт явуулъя.

Зөвшөөрсөн: 9  
Татгалзсан: 3  
Бүгд: 12  
75.0 хувийн саналаар Байнгын хорооны тогтоол батлагдлаа.

*Уг асуудлыг 17 цаг 08 минутад хэлэлцэж дуусав.*

*Долоо.Байнгын хорооны тогтоолын төсөл /Ажлын хэсэг байгуулах тухай/*

Хуралдаанд Улсын Их Хурлын Тамгын газрын Хууль, эрх зүйн газрын Байнгын хорооны асуудал хариуцсан хэлтсийн дарга Г.Агар-Эрдэнэ, мөн хэлтсийн Төрийн байгуулалтын байнгын хороо хариуцсан ахлах зөвлөх Б.Хатантуул, референт Э.Баттогтох нар байлцав.

Байнгын хорооны дарга Н.Энхболд тогтоолын төслийн талаар танилцуулав.

Тогтоолын төсөлтэй холбогдуулан Улсын Их Хурлын гишүүдээс асуулт, санал гараагүй болно.

**Н.Энхболд:** “Ажлын хэсгийн бүрэлдэхүүнд өөрчлөлт оруулах тухай” Байнгын хорооны тогтоолын төслийг батлах санал хураалт явууля.

Зөвшөөрсөн: 7  
Татгалзсан: 5  
Бүгд: 12  
58.3 хувийн саналаар Байнгын хорооны тогтоол батлагдлаа.

*Уг асуудлыг 17 цаг 11 минутад хэлэлцэж дуусав.*

Байнгын хорооны хуралдаанаар 7 асуудал хэлэлцэв.

*Хуралдаан 1 цаг 17 минут үргэлжилж, ирвэл зохих 19 гишүүнээс 14 гишүүн хүрэлцэн ирж, 73.7 хувийн ирцтэйгээр 17 цаг 12 минутад өндөрлөв.*

Тэмдэглэлтэй танилцсан:  
ТӨРИЙН БАЙГУУЛАЛТЫН  
БАЙНГЫН ХОРООНЫ ДАРГА

Н.ЭНХБОЛД

Тэмдэглэл хөтөлсөн:  
ХУРАЛДААНЫ ТЭМДЭГЛЭЛ  
ХӨТЛӨХ АЛБАНЫ ШИНЖЭЭЧ

Д.ОТГОНДЭЛГЭР

## МОНГОЛ УЛСЫН ИХ ХУРАЛ

2024 оны 01 дүгээр сарын 16-ний өдөр,  
Мягмар гараг  
Төрийн ордон “Жанжсин Д.Сүхбаатар”  
танхим  
15 цаг 55 минут.

### ТӨРИЙН БАЙГУУЛАЛТЫН БАЙНГЫН ХОРООНЫ ХУРАЛДААНЫ ДЭЛГЭРЭНГҮЙ ТЭМДЭГЛЭЛ

**Н.Энхболд:** Төрийн байгуулалтын  
байнгын хорооны гишүүддээ энэ өдрийн  
мэнд хүргэе. Ирц бүрдсэн байна.

Ирц Адьясүрэн гишүүн,  
Мөнхцэцэг гишүүн, Сүхбаатар гишүүн,  
Доржханд гишүүн, Оюунчимэг гишүүн,  
Тогтохсүрэн гишүүн, Жаргалмаа гишүүн,  
Энхболд гишүүн, Занданишатар дарга,  
Пүрэвдорж гишүүн ирээд 11 хүний  
ирцтэйгээр хуралдаан эхлэхэд бэлэн  
болж байна.

Төрийн байгуулалтын байнгын  
хорооны 2024 оны 1 сарын 6-ны өдрийн  
хуралдаан нээснийг мэдэгдье. Хэлэлцэх  
асуудлуудаа танилцуулъя.

“Төрийн байгууллагуудыг бүсчлэн  
байршуулах тухай” Улсын Их Хурлын  
тогтоолын төсөл, Засгийн газар 2024  
оны 1 сарын 5-ны өдөр өргөн мэдүүлсэн.  
Байнгын хороогоор анхны хэлэлцүүлэг  
хийнэ. Чуулганаар хэлэлцэх эсэхийг нь  
дэмжчихсэн байгаа.

Олон нийтийн радио, телевизийн  
Үндэсний зөвлөлийн гишүүнийг томилох,  
чөлөөлөх асуудлыг хэлэлцэнэ.

Төрийн албаны зөвлөлийн  
гишүүдийг томилох, чөлөөлөх тухай  
асуудал хэлэлцэнэ.

“Монгол Улсын Их Хурлын 2024  
оны хаврын ээлжит чуулганаар хэлэлцэх

асуудлын тухай” Их Хурлын тогтоолын  
төсөл хэлэлцэнэ.

“Хянан шалгах түр хороо  
байгуулах тухай” Улсын Их Хурлын  
тогтоол хэлэлцэнэ.

Байнгын хорооны “Ажлын хэсгийн  
бүрэлдэхүүнд өөрчлөлт оруулах тухай”  
тогтоолын төсөл хэлэлцэнэ.

“Ажлын хэсэг байгуулах тухай”  
Байнгын хорооны тогтоолын төсөл  
хэлэлцэнэ.

Хэлэлцэх асуудал дээр саналтай  
гишүүн байна уу? Алга байна. Асуудалдаа  
орцгооё.

“Төрийн байгууллагуудыг бүсчлэн  
байршуулах тухай” Улсын Их Хурлын  
тогтоолын төслийн анхны  
хэлэлцүүлгийг явуулъя.

Ажлын хэсгийн гишүүдийг дуудъя.

Амарсайхан сайд, Шадар сайд,  
Засгийн газрын Хэрэг эрхлэх газрын  
Тэргүүн дэд дарга Ганбат, Засгийн  
газрын Хэрэг эрхлэх газрын Хууль, эрх  
зүйн газрын дарга Дондогмаа, Засгийн  
газрын Хэрэг эрхлэх газрын Засгийн  
газрын референт Дөлгөөнтуул, Эдийн  
засаг, хөгжлийн яамны бүс нутаг аж  
үйлдвэрийн бодлогын газрын дарга  
Эрдэнэбаяр нар хүрэлцэн ирсэн байна.

Төслийн тогтоолын төслийг  
тараачихсан байгаа гишүүдэд тийм ээ?  
Анхны хэлэлцүүлэг байгаа. Энэ дээр  
зарчмын зөрүүтэй 1 санал байна уу? Их  
Хурлаар хэлэлцэх эсэхийг нь шийдчихсэн  
байж байгаа. Энэ дээр Байнгын хорооны  
зүгээс 2 зарчмын зөрүүтэй саналын  
томъёолол оруулж байна. Нэгдүгээр  
заалттай холбоотой Засгийн газраас  
оруулж ирэхдээ хот, хөдөөгийн хөгжлийн  
ялгаа энэ биш байна.

1.1 дүгээр заалт төрийн  
байгууллагуудын эрхлэх асуудал, чиг  
үүрэг, үзүүлэх үйлчилгээ, үйл



ажиллагааны хамрах хүрээг харгалзан бүсчлэн нийслэл Улаанбаатар хотоос үе шаттайгаар нүүлгэн байршуулах арга хэмжээ авах гэсэн томъёололтой орж ирсэн. Шууд бодлого нь гараагүй бусад хууль, эрх зүйн зүйлүүд хийгдээгүй байхад нүүлгэн шилжүүлээд эхлэх нь зохихгүй гэж үзсэн Байнгын хорооноос.

Тэгээд саяын томъёоллыг “Төрийн байгууллагуудыг бүсчлэн байршуулах тухай” тогтоолын төслийн 1 дэх заалтын 1 дэх дэд хэсгийн заалтын арга хэмжээ авах гэснийг талаарх бодлогыг боловсруулах гэж өөрчлөх тухай санал оруулж байна. Санаа нь юу вэ гэхээр эхлээд бодлогоо тодорхой боловсруулчихаад тэр нь батлагдсаны дараа нүүлгэн шилжүүлэхтэй холбоо, төрийн албан хаагчдад дэмжлэг үзүүлэх, нийгмийн баталгааг нь хангах асуудлуудыг судалж холбогдох хууль тогтоомжид өөрчлөлт оруулах. Мөн гуравдугаарт нь санхүүжилтийн эх үүсвэрээ улсын төсөвт тусгаж байх тухай ийм агуулгатай 3 заалттай байсан 1 дүгээр заалт бол 1.1, 1.2, 1.3 нь.

Саяын миний уншсан томъёоллоор арга хэмжээ авах гэдгийг энэ талаарх бодлогыг боловсруулах гэж өөрчлөх санал оруулж байна. Саналтай гишүүн байна уу? Тэгвэл санал хураана даа. Одоо гишүүдээ дуудъя. Харин тэнд бас санал хураах арай л болоогүй харагдсан даа. Хараадах яг хэдэн хүн үг хэлэхээр байна? Айн тийм үү? Дотогш нь утасд л даа. Ороод ирчихвэл эхнийх нь дороо л явчихна л даа. Санал хураахад ирц арай хүрэхгүй байна. Цаана чинь хэдэн хүн хүлээх гэж байна Батсуурь гишүүн ээ? Одоо бид 4 байна. Бас тийм байна.

“Төрийн байгууллагуудыг бүсчлэн байршуулах тухай” тогтоолын төслийн 1.1-ийн арга хэмжээ авах гэснийг талаарх бодлогыг боловсруулах гэж өөрчлөх зарчмын зөрүүтэй санал орж байгаа юм. Саналыг дэмжье гэсэн санал хураалт явуулъя. Санал хураалт. Явна

53.8 хувиар санал дэмжигдэж байна.

Хоёр дахь санал байгаа зарчмын зөрүүтэй. Энэ 1.2 дээр бас хэрэв шаардлагатай бол холбогдох хууль тогтоомжид нэмэлт, өөрчлөлт оруулах санал боловсруулж, шийдвэрлүүлэх гэсэн томъёоллоор Засгийн газраас орж ирсэн. Хэрэв энэ бодлого гарвал тэртээ тэргүй төрийн албан хаагчдыг шилжүүлэх, дэмжлэг үзүүлэхтэй холбоотой, нийгмийн баталгааг нь хангахтай холбоотой асуудлыг хууль тогтоомж гарч таарна гэж үзээд заавал шаардлагатай байх гэж үг хэрэггүй гэдгийг нь хасъя гэсэн ийм санал оруулж байгаа юм. Санал хураалт. Гишүүд ээ санал хураалт.

58.3 хувиар санал дэмжигдэж байна.

“Төрийн байгууллагуудыг бүсчлэн байршуулах тухай” Их Хурлын тогтоолын төслийн анхны хэлэлцүүлгийг явуулж дууслаа.

Санал, дүгнэлтийг Сарангэрэл гишүүн ойрд уншаагүй байх тээ. Сарангэрэл гишүүн Их Хурлын чуулганы хуралдаанд танилцуулна. Хоёр дахь асуудалдаа оръё.

16.06 цаг

**Олон нийтийн радио, телевизийн Үндэсний зөвлөлийн гишүүнийг томилох тухай, чөлөөлөх тухай асуудал байгаа.**

Энэ асуудлаар сонсгол явуулсан, тайлан гарсан байгаа хуулийн дагуу. Сонсголыг Сарангэрэл гишүүн удирдаж явуулсан. Уг сонсголын тайланг сонсгол удирдсан гишүүн Сарангэрэл танилцуулна. Ажлын хэсэг дээр Ноовийн Нанзаддорж. Ороод ирсэн байж байна. Сарангэрэл гишүүн.

**Д.Сарангэрэл:** Байнгын хорооны дарга, эрхэм гишүүд ээ,

Олон нийтийн радио, телевизийн Үндэсний зөвлөлийн гишүүнд нэр дэвшигчтэй хийсэн нэр дэвшигчийн сонголыг Олон нийтийн радио, телевизийн хуулийн 21 дүгээр зүйл зүйлд 21.6 үндэсний зөвлөлийн бүрэлдэхүүнд оруулахаар түүх, уламжлал, ёс заншил, соёл, урлаг, утга зохиол, шинжлэх ухааны чиглэлээр үйл ажиллагаа явуулдаг төрийн бус байгууллагууд тухайн чиглэлээр мэргэшсэн хүний нэрийг Монгол Улсын Ерөнхийлөгч санал болгоно, 21.7 төрийн бус байгууллагуудын саналаас сонголт хийн Үндэсний зөвлөлийн гишүүнд нэр дэвшүүлж, Улсын Их Хуралд өргөн мэдүүлнэ. Нэр дэвшсэн хүмүүсийг Улсын Их Хурлын нэр дэвшигчийн сонголт хийсний үндсэн дээр хэлэлцэж Үндэсний зөвлөлийн гишүүнээр томилно гэж заасны дагуу Монгол Улсын Их Хурлын хяналт шалгалтын тухай хуулийн 31 дүгээр зүйлийн нэр дэвшигчийн сонголын үе шатыг баримтлан дараах ажиллагааг явууллаа.

1. Монгол Улсын Ерөнхийлөгчөөс нэр дэвшүүлсэн Ноовойн Нанзаддорж нь Төрийн байгуулалтын байнгын хорооны 2022 оны 15 дугаар тогтоолоор баталсан нэр дэвших тухай хүсэлтийн загварын дагуу материалаа бүрдүүлж Байнгын хороонд ирүүлсэн болно.

2. 2024 оны 1 дүгээр сарын 2-ны өдрийн Байнгын хорооны хуралдаанаар Монгол Улсын Их Хурлын чуулганы хуралдааны дэгийн тухай хуулийн 119 дүгээр зүйлийн 119.1 дэх хэсэг, Монгол Улсын Их Хурлын хяналт шалгалтын тухай хуулийн 31 дүгээр зүйлийн 31.3-д заасны дагуу Олон нийтийн радио, телевизийн Үндэсний зөвлөлийн гишүүнээр нэр дэвшигчтэй хийх нэр дэвшигчийн сонголын тов, сонголт дарлагчийг тогтоох тухай тогтоолыг баталж, 2024 оны 1 дүгээр сарын 16-ны өдөр нэр дэвшигчийн сонголыг зохион байгуулахаар сонголт даргалагчаар Улсын Их Хурлын гишүүн нь

Даваажанцангийн Сарангэрэлийг томилсон.

3. Сонголын бэлтгэл хангах хүрээнд

Нэр дэвшигчийн мэдээллийг [parliament.mn](http://parliament.mn) буюу Улсын Их Хурлын цахим хуудаст байршуулсан.

Сонголын тов, хугацаа, сонголт оролцогчдыг бүртгэх хуудсыг байршуулсан зарыг Улсын Их Хурлын цахим хуудас, 24 [tsag.mn](http://tsag.mn), [mnb.mn](http://mnb.mn), [time.mn](http://time.mn), [montsame.mn](http://montsame.mn), [mongoltur.mn](http://mongoltur.mn), [uih.mn](http://uih.mn), [asuu.mn](http://asuu.mn), [isee.mn](http://isee.mn), [medee.mn](http://medee.mn), [toim.mn](http://toim.mn), [ubn.mn](http://ubn.mn), [chuhag.mn](http://chuhag.mn), [miminfo.mn](http://miminfo.mn), [zogii.mn](http://zogii.mn), [nio.mn](http://nio.mn), [analiz.mn](http://analiz.mn), [gogo.mn](http://gogo.mn), [newswire.mn](http://newswire.mn), [eguur.mn](http://eguur.mn), [beta.gogo.mn](http://beta.gogo.mn), [surag.mn](http://surag.mn), [tug.mn](http://tug.mn), [eagle.mn](http://eagle.mn), [ikon.mn](http://ikon.mn), [focus.mn](http://focus.mn), [dardas.mn](http://dardas.mn), [hardnews.mn](http://hardnews.mn) зэрэг 14 хоногийн хугацаанд давтамжтай байршуулсан.

Мэдээллийн дагуу оролцогч, ажиглагчаар бүртгүүлсэн иргэн, хуулийн этгээд гараагүй болно.

4. 2024 оны 1 дүгээр сарын 16-ны өдрийн 13 цаг 15 минутад Төрийн байгуулалтын байнгын хорооны гишүүдийн гуравны нэгээс доошгүй нь хүрэлцэн ирсээр ирц бүрдэх бөгөөд Байнгын хорооноос сонголт Улсын Их Хурлын гишүүн Амарсайхан, Батсуурь, Мөнхцэцэг, Мөнх-Оргил, Оюунчимэг, Тогтохсүрэн, Сарангэрэл, Жаргалмаа, Энхболд нар хүрэлцэн ирж, ирц бүрдэж, нэр дэвшигчийн сонголыг зохион байгуулсан болно.

Монгол Улсын Их Хурлын чуулганы хуралдааны дэгийн тухай хуулийн 127 дугаар зүйлд заасны дагуу сонголт оролцсон гишүүд сонголт явуулснаас хойш 2 өдрийн дотор хаалттай хуралдаж, хуралдаанд оролцсон гишүүдийн олонхын саналаар сонголын тайлан гаргана. Тайланд сонголын дүнд үндэслэн тухайн нэр дэвшигч албан тушаалд шаардлага

хангасан эсэх дүгнэлт, түүний үндэслэлийг тусгана.

Тухайн тайланг ажлын 5 өдрийн дотор нэр дэвшигч түүний санал болгосон этгээдэд хүргүүлж, парламентын цахим хуудаст байршуулах болно гэсний дагуу 2024 оны 1 дүгээр сарын 16-ны өдөр хаалттай хуралдаж, хуралдаанд оролцсон гишүүдийн олонхын саналаар сонсголын тайланг гаргалаа.

Нэр дэвшигчийн сонголд оролцсон гишүүд хаалттай хуралдаж, нэр дэвшигч Ноовойн Нанзаддоржийн ирүүлсэн материал болон сонсголын үр дүнд үндэслэн Олон нийтийн радио, телевизийн Үндэсний зөвлөлийн гишүүнд тавигдах шаардлагыг хангасан гэж үзэн хуралдаанд оролцсон гишүүд санал нэгтгэйгээр дэмжлээ.

Олон нийтийн радио, телевизийн Үндэсний зөвлөлийн гишүүнд санал болгосон нэр дэвшигчийн талаарх сонсголын тайланг хэлэлцэн шийдвэрлэж өгөхийг та бүхнээс хүсье.

Анхаарал тавьсанд баярлалаа.

**Н.Энхболд:** Сарангэрэл гишүүнд баярлалаа. Тайлан, нэр дэвшигчээс асуух гишүүн байна уу? Байхгүй байна.

Үг хэлэх гишүүн байна уу? Түрүүн бид нар сонсгол дээрээ бас нэлээн дэлгэрэнгүй сайн ярилцчихсан. Тийм, одоо тэгвэл санал хураалт явна л даа. Нэгэнт тогтоол гарах ёстой эхлээд бид нар одоогийн ажиллаж байгаа хүнийг нь өөрийнх нь хүсэлтийн дагуу чөлөөлөх талаар санал хураалт явуулна.

Олон нийтийн радио, телевизийн Үндэсний зөвлөлийн гишүүн Дуламрагчаагийн Жавзандоржийг Олон нийтийн радио, телевизийн Үндэсний зөвлөлийн гишүүнээс чөлөөлье гэсэн саналаар санал хураалт явуулна. Санал хураалт. Сая хамба болсон Жавзандорж хамбыг. Өөрөө хүсэлтээ гаргасан. Тийм.

12 гишүүн оролцож, 66.7 хувиар санал дэмжигдлээ.

Одоо Ноовойн Нанзаддоржийг Монголын үндэсний олон нийтийн радио, телевизийн Үндэсний зөвлөлийн гишүүнээр томилох саналыг дэмжье гэсэн томъёолоор санал хураалт явуулъя. Санал хураалт.

Нууц санал хураалт явж, 12 гишүүн оролцсоноос 8 нь дэмжиж 66.7 хувиар санал дэмжигдлээ. Би тогтоолын төсөл уншиж танилцуулъя.

Монгол Улсын Их Хурлын тогтоол. “Монголын үндэсний олон нийтийн радио, телевизийн Үндэсний зөвлөлийн гишүүнээр томилох, гишүүнээс чөлөөлөх тухай” Монгол Улсын Их Хурлын чуулганы хуралдааны дэгийн тухай хуулийн 108 дугаар зүйлийн зүйлийн 100. 18.2 дахь хэсэг, Олон нийтийн радио, телевизийн тухай хуулийн 21 дүгээр зүйлийн 21.2. 21.8 дахь хэсэг, 26 дугаар зүйлийн 26.1.1 дэх заалтыг үндэслэн Монгол Улсын Их Хурлаас ТОГТООХ нь:

1.Ноовойн Нанзаддоржийг Монголын үндэсний олон нийтийн радио, телевизийн Үндэсний зөвлөлийн гишүүнээр томилсугай

2.Дуламрагчаагийн Жавзандоржийг өөрийнх нь гаргасан хүсэлтийг үндэслэн Монголын үндэсний телевиз, Олон нийтийн радио, телевизийн Үндэсний зөвлөлийн гишүүнээс чөлөөлсүгэй.

Энэ тогтоолыг баталсан өдрөөс нь эхлэн дагаж мөрдсүгэй гэсэн ийм тогтоолын төсөл байна.

Асуулттай гишүүн байна уу? Үг хэлэх гишүүн байна уу тогтоолтой холбогдуулж? Алга байна.

Тогтоолын төслийг батлагдсанд тооцлоо, дэмжлээ.

Байнгын хорооны санал, дүгнэлтийг нэгдсэн хуралдаанд Сарангэрэл гишүүн өөрөө танилцуулчихъя. Дараагийн асуудалдаа оръё. Хоёр дахь асуудлаа хэлэлцээж дууслаа.

16.14 цаг

**Төрийн албаны зөвлөлийн гишүүнийг томилох, чөлөөлөх тухай асуудлыг хэлэлцэнэ.**

Мөн бид нар хуульд заасны дагуу сонсгол зарласан, сонсголыг Улсын Их Хурлын гишүүн Мөнхцэцэг удирдаж явуулсан. Ажлын хэсэг Төрийн албаны зөвлөлийн гишүүнд нэр дэвшигч Л.Цэдэвсүрэн, Б.Пүрэвдагва нар оролцож байна.

Сонсголын тайланг сонсгол удирдаж явуулсан Мөнхцэцэг гишүүн танилцуулна. Мөнхцэцэг гишүүний микрофоныг өгье.

**Ц.Мөнхцэцэг:** Байнгын хорооны дарга, эрхэм гишүүд ээ,

Төрийн албаны зөвлөлийн гишүүнд нэр дэвшигч нартай хийсэн нэр дэвшигчийн сонсголыг Төрийн албаны тухай хуулийн 68 дугаар зүйлийн 68.1 дэх хэсэгт зөвлөл нь хамтын удирдлагын зарчмаар ажиллах бөгөөд орон тооны 5 гишүүний бүрэлдэхүүнтэй байна, 68.2-т зөвлөлийн гишүүнд Улсын Их Хурлын Тамгын газар, Засгийн газрын Хэрэг эрхлэх газар тус бүр 1 хүнийг нэр дэвшүүлэх бөгөөд нэр дэвшигч нь төрийн жинхэнэ албан тушаалд 15-аас доошгүй жил ажилласан төрийн удирдлага, эдийн засаг, эрх зүй, боловсролын чиглэлээр мэргэшсэн дээд боловсролтой ял шийтгүүлж байгаагүй 45 нас хүрсэн Монгол Улсын иргэн байна, 68.3-д Улсын Их Хурал нэр дэвшигчийн сонсгол хийсний үндсэн дээр Зөвлөлийн гишүүнийг 6 жилийн хугацаагаар томилно гэж заасны дагуу Монгол Улсын Их Хурлын хяналт шалгалтын тухай хуулийн 31 дүгээр зүйлийн нэр дэвшигчийн сонсголын

үе шатыг баримтлан дараах ажиллагааг явууллаа.

1.Улсын Их Хурлын Тамгын газраас нэр дэвшүүлсэн Баярын Пүрэвдагва, Засгийн газрын Хэрэг эрхлэх газраас нэр дэвшүүлсэн Лхагвын Цэдэвсүрэн нар Төрийн байгуулалтын байнгын хорооны 2022 оны 15 дугаар тогтоолоор баталсан нэр дэвших тухай хүсэлт загварын дагуу материалаа бүрдүүлж Байнгын хороонд ирүүлсэн болно.

2.2024 оны 1 дүгээр сарын 2-ны өдрийн Байнгын хорооны хуралдаанаар Монгол Улсын Их Хурлын чуулганы хуралдааны дэгийн тухай хуулийн 119 дүгээр зүйлийн 119.1 дэх хэсэг, Монгол Улсын Их Хурлын хяналт шалгалтын тухай хуулийн 31 дүгээр зүйлийн 31.3 дахь хэсэгт заасны дагуу Төрийн албаны зөвлөлийн гишүүд нэр дэвшигчтэй хийх, нэр дэвшигчийн сонсголын тов, сонсгол зарлагчийг сонгох тухай Төрийн байгуулалтын байнгын хорооны 2024 оны 2 дугаар тогтоолоор Нэр дэвшигчийн сонсголыг 2024 оны 1 дүгээр сарын 16-ны өдөр зохион байгуулахаар сонсгол даргалагчаар Улсын Их Хурлын гишүүн Цэрэнжамцын Мөнхцэцэгийг томилсон.

3.Сонсголын бэлтгэл хангах хүрээнд

Нэр дэвшигчийн мэдээллийг [parliament.mn](http://parliament.mn) буюу Улсын Их Хурлын цахим хуудас байршуулсан.

Сонсголын тов, хугацаа сонсголд оролцогчийг бүртгэх хуудсыг байршуулсан зарыг Улсын Их Хурлын цахим хуудас, [itoim.mn](http://itoim.mn), [ikon.mn](http://ikon.mn), [24tsag.mn](http://24tsag.mn), [live.mn](http://live.mn), [eguir.mn](http://eguir.mn), [news.mn](http://news.mn), [newpress.mn](http://newpress.mn), [times.mn](http://times.mn), [tovch.mn](http://tovch.mn), [zarig.mn](http://zarig.mn), монгол 88 fm, радио зэрэг 14 хоногийн хугацаанд давтамжтай байршуулсан.

Мэдээллийн дагуу 1 ажиглагч бүртгүүлснийг Монгол Улсын Их Хурлын чуулганы хуралдааны дэгийн тухай хуулийн дагуу Байнгын хороо хүсэлтийг

хүлээн авсан огноо, цаг, минутаар бүртгэж, баталгаажуулсан.

Анхаарал хандуулсанд баярлалаа.

2024 оны 1 дүгээр сарын 16-ны өдрийн 10 цагт Төрийн байгуулалтын байнгын хорооны гишүүдийн гуравны нэгээс доошгүй нь хүрэлцэн ирснээр ирц бүрдсэн бөгөөд Байнгын хорооноос сонсголд Улсын Их Хурлын гишүүн Амарсайхан, Батсуурь, Жаргалмаа, Мөнх-Оргил, Мөнхцэцэг, Оюунчимэг, Сарангэрэл, Тогтохсүрэн, Энхболд нар хүрэлцэн ирж, ирц бүрдэж, нэр дэвшигчийн сонсголыг зохион байгуулсан болно.

Монгол Улсын Их Хурлын чуулганы хуралдааны дэгийн тухай хуулийн 127 дугаар зүйлд заасны дагуу сонсголд оролцсон гишүүд сонсгол явснаас хойш 2 өдрийн дотор хаалттай хуралдаж, хуралдаанд оролцсон гишүүдийн олонхын саналаар сонсголын тайлан гаргана.

Тайланг сонсголын үр дүнд үндэслэн тухайн нэр дэвшигч албан тушаалд шаардлага хангасан эсэх дүгнэлт, түүний үндэслэлийг тусгана. Тухайн тайлан ажлын 5 өдрийн дотор нэр дэвшигч, түүний санал болгосон этгээдэд хүргүүлж парламентын цахим хуудас байршуулах болно гэж заасны дагуу 2024 оны 1 дүгээр сарын 16-ны өдөр хаалттай хуралдаж, хуралдаанд оролцсон гишүүдийн олонхын саналаар сонсголын тайланг гаргалаа.

Нэр дэвшигчийн сонсголд оролцсон гишүүд хаалттай хуралдаж, нэр дэвшигч Баярын Пүрэвдагва, Лхагвын Цэдэвсүрэн нарын ирүүлсэн материал болон сонсголын үр дүнд үндэслэн Төрийн албаны зөвлөлийн гишүүнд тавигдах шаардлагыг хангасан гэж үзэж хуралдаанд оролцсон гишүүд санал нэгтгэйгээр дэмжлээ.

Төрийн албаны зөвлөлийн гишүүнд санал болгосон нэр дэвшигчийн талаарх сонсголын тайланг хэлэлцэн шийдвэрлэж өгнө үү.

**Н.Энхболд:** Мөнхцэцэг гишүүнд баярлалаа. Сонсголын тайлан, нэр дэвшигч нараас асуулттай гишүүн байна уу? Байхгүй байна.

Санал хэлэх гишүүн байна уу? Мөнх-Оргил гишүүн.

**Ц.Мөнх-Оргил:** Баярлалаа. Би сонсголд оролцож нэр дэвшиж байгаа хоёр хүнийг дэмжсэн байгаа. Улсын Их Хурал, Засгийн газар зөв хүмүүсийг нэр дэвшүүлсэн байна гэж би хувьдаа үнэлж байгаа. Аль аль нь төрийн албаны асар их дадлага, туршлагатай. Цэдэвсүрэн дарга бол салбар төдийгүй ер нь энэ төрийн албыг ямар байх ёстойг маш сайн мэддэг ийм мэргэжлийн хуульч, мэргэшсэн төрийн албан хаагч очиж байгаа юм байна.

Манай Улсын Их Хурлын Тамгын газраас нэр дэвшүүлж байгаа Пүрэвдагвыг ч гэсэн бас олон жил мэднэ. Урьд нь манай Сүхбаатар дүүргийн Тамгын газарт ажиллаж байхаас нь эхлээд хамтарч ажиллаж байсан. Та бүгдэд ажлын их амжилтыг хүсье.

Санал хэлэхэд энэ Төрийн албаны зөвлөлийн ажлыг нэг талаас шинэ шатанд гаргах, бид нар анх энэ Төрийн албаны зөвлөлийн хуулийг шинэчлээд л, төрийн албаны шинэчлэлийг эхлүүлж байх хэмжээнд хүсэн хүлээж байсан тэр түвшинд гарах тал дээр шинээр томилогдож очоод та хэд ихээхэн хичээл зүтгэл гаргаж ажиллаарай. Төрийн албаны зөвлөлд очихлоороо л төрийн албан хаагчдыг л зөвхөн хамгаалаад байх л юм манай зарим Төрийн албаны зөвлөлийн гишүүд бодоод байдаг. Энэ хамгаалах мэдээж байлгүй яах вэ. Хамгийн гол нь энэ төрийн албанд яаж энэ мэргэшсэн, чадалтай хүмүүсийг татаж оролцуулах вэ, тогтвор суурьшилтай ажиллуулах вэ, ямар бололцоогоор хангах вэ, карьерын буюу шат дараалсан карьер хийдэг энэ

бололцоог бүрдүүлэх үү гэдэг дээр л ихэд анхаарч ажилламаар юм байна л гэж бодсон.

Эцэст нь төрийн албанд орж ажиллах сонирхолтой тухайн салбарын өндөр мэдлэг, боловсролтой хүмүүсийг сургах, дахин сургах асуудал дээр их анхаармаар юм байна лээ гэж би энэ сүүлийн үед бодогдоод байдаг болчихоод байгаа юм. Энэ хуучнаар Удирдлагын академи дээр суурилсан маш том потенциал байна. Энэ потенциалыг сайн ашиглаж ажиллаарай гэж захъя. Баярлалаа.

**Н.Энхболд:** Баярлалаа. Би түрүүн сонсгол дээр бас байр сууриа илэрхийлж байсан. 93 оноос эхлээд энэ төрийн албыг шинэ Үндсэн хуулийн дагуу байгуулагдсан Монгол Улсын төрийн тогтолцоо нь дотор ямар төрийн албан хаагч байх ёстой юм, тэр хүмүүс ямар үүрэг, хариуцлагатай байх ёстой юм, яаж тэд нарыг шилжэж сонгож, дэвшүүлж хариуцлага тооцож байх юм гэдэг талаар цоо шинэ зүйлүүд орсон ийм хууль гараад 32 жил, 30-аад жил болчихлоо. Хэд хэдэн удаа хуульд өөрчлөлт орсон, шинэчлэгдсэн. Хамгийн сүүлд Төрийн албан хаагчийн ёс зүйн тухай хууль гэж батлагдсан. Яагаад анхнаасаа энэ хууль батлагдаагүй байсан гэхээр тэр тухайн үеийн асуудал байх.

Ер нь 30-аад жил мөрдөөд ирэхэд өнөөдөр төрийн албанд мэдээж эхний ээлжид нөгөө мерит зарчим буюу чадахуйн зарчмаараа дэвшдэг, ажилладаг үүндээ таарсан хүмүүсээ бэлддэг, сонгодог энэ шаардлага нэн түрүүнд тавигдсан.

Хоёрдугаарт улс төрөөс ангид, тогтвортой ажиллаад мэргэшиж, тэр мэргэшсэнийхээ дагуу тэр мерит зарчмаар явж байдаг ийм л тогтолцоог бид нар бий болгох гэж оролдсон юм. Энэ хооронд анзаарагдсан хамгийн гол зүй бол нь ер нь нийгэмд маань ч бас дутагдаж байгаа нэг том зүйл нь ёс зүй, ёс суртахууны асуудал. Түүн дотроо

төрийн албан хаагчдын дунд анхаарал татаж, хууль гаргахаас өөр аргагүй байдалд хүрсэн гэж болохоор нэг зүйл бол энэ ёс суртахуун, ёс зүйн тухай асуудал байгаа. Үүний дагуу хууль гаргасан, анхдагч хууль гарсан.

Тэгэхээр би түрүүн сонсголын үеэр ярьсан зүйлээ дахиад давтаад та бүхэнд хэлэхэд одоо энэ хуулийн дагуу Төрийн албаны зөвлөлийн дэргэд Ёс зүйн хороо гээд байгуулагдчихсан байгаа. Тэр Ёс зүйн хороо бүх төрийн байгууллагад хүрч ажиллахад бол төвөгтэй. Бүх байгууллагуудын дэргэд Ёс зүйн дэд хороо байгуулагдаж байгаа, зарим нь байгуулагдсан, зарим нь байгуулагдаж байгаа байх.

Тэгэхээр энэ дэд хороодыг их зөв бүрэлдэхүүнтэй сонгох тал дээр нь та бүхэн мэргэжлийн арга зүйн талаас нь туслалцаа, дэмжлэг үзүүлж их анхааралтай хандаж байх хэрэгтэй юм байгаа юм. Бидэнд бас зөндөө мэдээллүүд байдаг шүү дээ. Жишээ нь нэг газраас тэр яамны Ёс зүйн хороонд ийм ийм хүмүүс орлоо гээд та нар дээр мэдээлэл ирлээ гэж бодоход магадгүй өөр бусад шугамаар үгүй наадах чинь урьд өмнө ёс зүйн хувьд, ёс суртахууны хувьд ийм алдаа гаргаж байсан хүн байна шүү дээ гэдэг нь нотлогдсон тийм юм явж байвал жишээ нь та нар хөөе та нар ингэж болж байгаа юм уу, наад хүн чинь өөрөө ийм байсан мөртөө бусдыгаа ёс зүйтэй, ёс суртахуунтай байлгаж чадах уу, үгүй юү гэдэг дээр нь хүртэл шаардлага, анхаарал тавьж ажиллаж байх ёстой шүү гэдгийг хэлсэн. Эхний ээлжид бол энэ зохион байгуулалтын асуудал дээр үүнийг сайн анхаарч ажиллахаар үзье бүгдээрээ. Хууль намын дагуу байж байгаа. Хоёр нэр дэвшигчийн хувьд бол асуудал байхгүй. Хоёулаа төрийн албанд олон жил ажилласан. Нэг нь бүүр Төрийн албаны зөвлөлд хүртэл 2 удаа ахлахаар, газрын даргаар ажиллаж байсан хүн.

Цэдэвсүрэн дарга бол төрийн албаны хамгийн анхан шатын нэгжээс

эхлээд төрийн сайд хүртэл хийчихсэн ийм олон жилийн туршилагатай манай эмэгтэй төрийн албан хаагчдын дунд бол бас өөрийн гэсэн байр сууриа олчихсон нэртэй төртэй ажиллаж ирсэн ийм хүн байгаа. Хоёуланг нь Төрийн албаны зөвлөлд бол маш сайн ажиллаж чадна гэдэгт би хувь хүнийхээ хувьд ч тэр, Улсын Их Хурлын гишүүний хувьд ч тэр итгэлтэй байгаа. Та бүхэнд хэрэв дэмжигдээд сонгогдвол ажилд нь амжилт хүсэж байна.

Одоо санал хураалт явуулна. Та байхгүй байсан даа. За тэг тэг. Түүрүүн нэрээ өгөөгүй учраас хурлаа явуулъя. Тогтохсүрэн гишүүн. Батсуурь гишүүн чуулган дээр хэлье гээд л уг нь гоё санаачилга гаргаад байдаг.

**Д.Тогтохсүрэн:** Хоёр гишүүнийг дэмжиж байна. Сонгон шалгаруулалт хийгдээд, сонсгол явагдаад тэгээд одоо Улсын Их Хурал руу орж томилогдох гэж байна. Би цаашидаа ажиллах зарчимтай холбоотой хоёр зүйлийг хэлье гэж бодож байгаа юм. Төрийн албаны зөвлөл маш хариуцлагатай байгууллага. Бид 2017 онд хуулийг нь баталж өгсөн. Хуулийн дагуу гарах 5, 6 журмыг нь баталж өгсөн. Тэгээд КОВИД-ын хууль, янз бүрийн сонгууль эд нар гээд хуулийн хэрэгжилт бас тийм хангалттай сайн байхгүй байгаа. Би энэ хоёр гишүүн очоод энэ Төрийн албаны хуулийн хэрэгжилтийг хангах, төрийн албан хаагчдын эрх ашгийг хамгаалах, төрийн албыг ил тод, нээлттэй, шударга явуулах, төрийн албан хаагчдад өрсөлдөх бололцоо, боломжийг нь бий болгох энэ чиглэлд бол онцгой анхаарал тавьж ажиллах ёстой Төрийн албаны зөвлөлийн гишүүд.

Өнөөдөр Монгол Улсад төрийн захиргааны жинхэнэ албан хаагч 60 орчим мянган албан хаагч бий. Нийт дүнгээрээ 200 гаруй мянган албан хаагч байна. Тийм учраас Төрийн албаны хуулийг хэрэгжүүлэх энэ чиглэлд онцгой анхаарал тавьж ажиллах шаардлагатай гэдгийг би зориуд энэ хоёр гишүүнд хэлье

гэж бодож байгаа юм. Төрийн албаны зөвлөлийн гишүүн бол Засгийн газар юм уу, хэн нэг төрийн байгууллагын санал хэрэгжүүлэгч байж болохгүй. Энэ бол хатуу санал. Манай Төрийн албаны зөвлөлийн гишүүд сонгон шалгаруулалт явуулах гэж байгаа нөхдүүдийн санал хэрэгжүүлэгч болчих гээд байдаг. Тийм юм огт байж болохгүй. Яг төрийн албаны хуульд юу гэж зааж байна карьерын зарчмаар шатлан дэвших тогтолцоогоороо явж байгаа тэр л хуулийг хатуу мөрдүүлэх ёстой. Хүнд тохируулж ажлын байр, ажлын байрны тодорхойлолт гаргаж болохгүй, хүнд тохируулж сонгон шалгаруулалт явуулж болохгүй. Энэ дээр ёстой хатуу байр суурь баримталж, эхнээс нь шударга, ил тод, нээлттэй явуулах чиглэлд би онцгой анхаарал тавьж ажиллаарай гэдгийг зориуд анхааруулж хэлье гэж бодож байгаа юм.

Хоёр дахь юм бол энэ төрийн албан хаагч нар бол бүгдээрээ энэ 17 оны хуулиас хойш шатлан дэвших тогтолцоонд ороод 15 жил, 20 жил ажилласны дараа эрхэлсэн буюу тэргүүн түшмэл болно гээд бүгдээрээ бодоод байж байгаа. Энэ өрсөлдөх боломжийг шатад нь бий болгож өгөх ёстой. Үүний төлөө Төрийн албаны хууль гарсан. Гэтэл дундуур нь янз бүрийн улс төрчдийн цүнх барьж гүйсэн хүн төрийн албанд шургуулж гүйж орж ирж ордог энэ нүхийг бүрэн хаах ёстой. Тэр хааж байх хүмүүс нь хэн байна вэ гэхээр Төрийн албаны зөвлөл. Төрийн албаны зөвлөл Засгийн газраас хараат бус ажиллах ёстой, Улсын Их Хурлаас хараат бус ажиллах ёстой. Тэгж Төрийн албаны зөвлөлийн энэ гурван гишүүний гурван субъектээс нэр дэвшүүлж байгаа. Ерөнхийлөгчөөс, Их Хурлаас, Засгийн газраас.

Нөгөө талд нь төрийн албан хаагчдын төлөөлөл болж хоёр гишүүн нэр дэвшиж байгаа. Энэ нь нөгөө хараат бус байдлынх нь баталгаа байгаа юм. Тийм учраас ийм хоёр асуудал дээр би Төрийн албаны зөвлөлийн шинээр

томилогдож байгаа гишүүдийг онцгой анхаарал тавьж ажиллаарай гэж хэлье. Ийм зүйлийг хэлье гэж бодож байна.

**Н.Энхболд:** Пүрэвдорж гишүүн үг хэлнэ.

**Б.Пүрэвдорж:** Тэгэхээр энэ чинь тийм сөрөг хүчингүй юм шиг ингээд л яваад л одоо Ардын намынхан өөрсдийнхөө албан тушаалтан, төрд ажиллаж байсан хүмүүсээ энд шахдаг л, энд тэнд хүмүүсээ томилдог л ийм л болж байна. Тэн дээр нь тэгээд л ийм Ардчилсан намынхан кнопоо дараад яваад байна гэсэн юм бас байхгүй. Дэмжээд байна ч гэсэн юм байхгүй. Ер нь одоо юу байдаг юм Цэдэвсүрэн гуай, дарга дээр би бас үг хэлье гэж бодож байна. Та одоо энэ Ардын намынхаа бас итгэлийг олоод тэр сайд хийсэн, Төрийн нарийн бичгийн дарга хийсэн. Энэ хугацаанд яасан боловсролын салбар чинь бас тийм асуудалд орчихсон байж байгаа шүү дээ. Өнгөрсөн 20 хэдэн жилийн туршид тэр Боловсролын зээлийн сан гээд л зөндөө асуудлууд байсан. Дарга нарынхаа тушаалаар заримдаа хамтран тонож байсан байх. Өөрөө дарга хийгээд бас тонож байсан байх. Ардын хүүхдийн сурах ёстой, боловсрох ёстой тэр санг ингээд л дампууруулж байсан.

Дээрээс нь авлигал янз янзын асуудлаар хэрэгт холбогдоод, шалгагдаад л ингээд явж байсан. Энэ боловсролын салбар чинь тийм сайн байхгүй байгаа шүү дээ. Тэгээд л одоо ингээд тийм явуулах болохлоороо л төрийн алба гээд. Тэр чинь төрийн албаны чинь хамгийн хариуцлагатай, хамгийн шалгуур хангасан хүмүүс тэнд ажиллаж, тэр байгууллагыг удирдаж, энэ төрийн албыг чадварлаг болгох, ард түмнийхээ төлөө бүрэн дүүрэн зүтгэдэг тэр хүмүүсийг сонгон шалгаруулах тэр ажлыг хийх ёстой юман дээр одоо ингээд л боловсролын салбар дээр өчнөөн олон жил ажиллачхаад амжилт гаргаагүй хүнийг томилно гэдэг байж болохгүй зүйл л гэж би үзэж байна.

Ер нь бол аль хэдийн ингээд юу байдаг юм энэ сайн боловсон хүчин танай намд зөндөө байгаа шүү дээ. Тэр хүмүүсээ олж гаргаж ирж томилуулах тэр асуудлыг та нар хийх хэрэгтэй байхгүй юу даа. Харамсалтай нь одоо ингээд л тийм тэтгэвэртээ гарах шахсан хүмүүсийг л ингээд л аваачиж томилдог ийм л байгууллага болж хувиргаж байна шүү дээ. Төрийн албан хаагч нар чинь хэнд итгэх юм? Төрийн албан хаагч албан хаагч нарынхаа хамгийн шударга ажиллах ёстой газар, шаардах ёстой газар дээр чинь ингээд салбар дээр ажиллаад, өчнөөн олон жил ажиллаад амжилтад хүрээгүй тийм хүмүүс ажиллаад явна гэдэг чинь буруу шүү дээ.

Тийм учраас та нар энэ хүмүүсийнхээ нэрийг татаж авах хэрэгтэй. Буцааж хүн оруулж ир л дээ. Бас төрийн албан хаагч нар итгэдэг тэр хүмүүсийг оруулж ир л дээ. Итгэл төрүүлэхүйц, салбартаа хүлээн зөвшөөрөгдсөн тийм олон боловсон хүчин танай намд зөндөө байгаа шүү дээ.

**Н.Энхболд:** Гишүүд байр сууриа илэрхийлж, үг хэлж дууслаа. Одоо санал хураалт явуулна. Байнгын хорооноос тогтоол гарах ёстой. Тогтоолын төслийг дараа нь танилцуулна. Одоо Төрийн албаны зөвлөлийн гишүүнээс эхлээд хугацаа нь дууссан гишүүдээ чөлөөлөх тухай асуудлаар, дараа нь нэр дэвшүүлж томилох тухай асуудлаар ярина, санал хураана.

Төрийн албаны зөвлөлийн гишүүн Балдангийн Баатарзоригийг Төрийн албаны зөвлөлийн гишүүнээс чөлөөлөхийг дэмжье гэсэн саналаар санал хураалт явуулна. Санал хураалт.

7 гишүүн дэмжиж, 58.3 хувиар дэмжиж байна.

Төрийн албаны зөвлөлийн гишүүн Самдангийн Цэдэндамбыг Төрийн албаны зөвлөлийн гишүүнээс чөлөөлөхийг



дэмжье гэсэн саналаар санал хураалт явуулна. Санал хураалт.

8 хүн дэмжиж, 66.7 хувиар санал дэмжигдэж байна.

Баярын Пүрэвдагвыг Төрийн албаны зөвлөлийн гишүүнээр томилуулах саналыг дэмжье гэсэн томъёоллоор санал хураалт явуулна. Санал хураалт.

58.3 хувиар санал дэмжигдэж байна.

Лхагвын Цэдэвсүрэнг Төрийн албаны зөвлөлийн гишүүнээр томилуулах тухай саналыг дэмжье гэсэн томъёоллоор санал хураалт явуулна. Амараа сайд саналаа өгөөрэй. Санал хураалт.

58.3 хувиар санал дэмжигдлээ.

Байнгын хорооны тогтоолын төсөл танилцуулъя.

Монгол Улсын Их Хурлын тогтоол “Төрийн албаны зөвлөлийн орон тооны гишүүнийг томилох, гишүүнээс чөлөөлөх тухай” Монгол Улсын Их Хурлын чуулганы хуралдааны дэгийн тухай хуулийн 108 дугаар зүйлийн 108.2 дахь хэсэг, Төрийн албаны тухай хуулийн 68 дугаар зүйлийн 68.2, 68.3 дахь хэсгийг үндэслэн Монгол Улсын Их Хурлаас ТОГТООХ нь:

Баярын Пүрэвдагва, Лхагвын Цэдэвсүрэн нарыг Төрийн албаны зөвлөлийн орон тооны гишүүнээр томилсугай.

2.Балдангийн Баатарзориг, Самдангийн Цэдэндамба нарын бүрэн эрхийн хугацаа дуусгавар болсон тул Төрийн албаны зөвлөлийн орон тооны гишүүний үүрэгт ажлаас чөлөөлсүгэй.

Энэ тогтоолыг баталсан өдрөөс нь эхлэн дагаж мөрдсүгэй гэсэн тогтоол байна.

Тогтоолын төсөлтэй холбогдуулж үг хэлэх гишүүн байна уу? Алга.

Мөнхцэцэг гишүүн Байнгын хорооны санал, дүгнэлтийг нэгдсэн хуралдаанд танилцуулъя. Дараагийн асуудалдаа оръё.

16.36 цаг

**“Монгол Улсын Их Хурлын 2024 оны хаврын ээлжит чуулганаар хэлэлцэх асуудлын тухай” Их Хурлын тогтоолын төслийг хэлэлцэнэ.**

Төрийн байгуулалтын байнгын хорооноос нам, эвслийн бүлэг, Байнгын, Дэд, Түр хороо хууль санаачлагчийн саналуудыг үндэслээд дараагийн ээлжит чуулганаар хэлэлцэх асуудлын талаарх тогтоолын төслийг боловсруулан нэгдсэн хуралдаанд оруулдаг. Хуралдаанд оролцсон гишүүдийн олонхын саналаар баталдаг ийм дэгтэй.

Үүний дагуу Улсын Их Хурал дахь намын бүлгүүд, Байнгын хороо, дэд хороо, түр хороо, хууль санаачилсан бусад гишүүдийн саналыг үндэслээд Монгол Улсын Их Хурлын чуулганы хуралдааны дэгийн тухай хуулийн 10 дугаар зүйлийн 10.1 дэх хэсэгт заасны дагуу “24 оны ээлжит хаврын ээлжит чуулганаар хэлэлцэх асуудлын тухай” Улсын Их Хурлын тогтоолын төслийг боловсруулсан.

Дэгийн тухай хуулийн 10 дугаар зүйлийн 10.3 дахь хэсэгт заасны дагуу саналууд ирсэн. Улсын Их Хурал дахь Монгол ардын намын бүлгээс 24, Ардчилсан намын бүлгээс 37, Засгийн газраас 50, Байнгын хороодоос 39, тогтоолын төсөл нийт давхардсан тоогоор 150 хууль тогтоомжийн төслийг албан бичгээр Байнгын хороонд ирүүлсэн.

Үүнээс давхардсан тоогоор 44 хууль тогтоомжийн төслийг тогтоолын

төсөлд тусгаж та бүхэнд танилцуулж байна.

Хаврын чуулганаар хэлэлцэх асуудлын тухай энэ төслийг боловсруулахдаа дараах хэдэн зарчмуудыг баримталаа. Юуны өмнө хаврын ээлжит чуулганаар хэлэлцэн батлахаар хуульд тусгайлан заасан ийм тогтоолын төслүүд, хууль, тогтоолын төслүүд байгаа. Заавал хэлэлцэх ёстой төслүүд.

Хоёрдугаарт, Монгол Улсын Үндсэн хуульд оруулсан нэмэлт, өөрчлөлтөд хууль тогтоомжийг нийцүүлэх, түүнтэй холбогдуулан авах арга хэмжээний тухай 20 оны 2 дугаар тогтоол Улсын Их Хурлаас гарсан. Энэ тогтоолын хавсралтад дурдсан Үндсэн хуулийн үзэл баримтлалд нийцүүлж өөрчлөх, шинэчлэх шаардлагатай хуулийн төслүүдийг оруулсан.

Гуравт, “Монгол Улсын Үндсэн хуульд оруулсан өөрчлөлттэй холбогдуулан авах арга хэмжээний тухай” мөн Улсын Их Хурал 23 онд 44 дүгээр тогтоол гаргасан. Энэ хуулийн төслүүдийг оруулсан. Монгол Улсын Засгийн газраас 20-24 оны үйл ажиллагааны хөтөлбөрөө хэрэгжүүлэхдээ шаардлагатай эрх зүйн орчныг бүрдүүлэх чиглэлээр тусгасан хууль тогтоомжийн төслүүдийг оруулсан.

Тавдугаарт, “Монгол Улсын хууль тогтоомжийг 24 он хүртэл боловсронгуй болгох үндсэн чиглэл батлах тухай” Улсын Их Хурал бас 21 онд 12 дугаар тогтоол гэж гаргасан. Энд туссан хууль тогтоомжийн төслүүдийг оруулсан. Их Хурлын 21 оны 106 дугаар тогтоолоор “Шинэ сэргэлтийн бодлого батлах тухай” асуудал хэлэлцэж шийдвэрлэсэн. Үүнд багтсан нэн яаралтай хэлэлцэх бусад болон өргөн мэдүүлэх хууль тогтоомжийн төслүүдийг мөн энд оруулсан. Хамгийн сүүлд “Хүнсний хангамж, аюулгүй байдлыг хангах

талаар авах зарим арга хэмжээний тухай” 2022 онд мөн Улсын Их Хурлаас 36 дугаар тогтоол гаргасан. Энэ хууль тогтоомжийн төслүүдийг тусгасан байгаа. Дахиад хэлэхэд 150 гаруй тогтоол, хууль орж ирсэн. Үүнээс 44-ийг нь тусгаад явж байна.

Мөн хэлэлцүүлгийн шатад хэлэлцүүлгийн шатад байгаа хууль санаачлах эрх бүхий субъектүүдээс өргөн мэдүүлсэн хууль, тогтоолын төслийг хэлэлцэх асуудлын дараалалд орох оруулах асуудлыг чуулганы явцад Улсын Их Хурлын даргын дэргэдэх зөвлөлийн саналыг харгалзаад Их Хурлын даргын шийдвэрээр тухайн үед нь шийдэж байхаар ийм зүйлүүдийг оруулсан байгаа. Та бүхэн тогтоолын төслийг тараачихсан байж байгаа. Саяын хэлсэн 44 хууль ороод.

Монгол Улсын Их Хурлын тухай хуулийн 18 дугаар зүйлийн 18.4 дэх хэсэг, Их Хурлын чуулганы хуралд дэгийн чуулганы хуралдааны дэгийн тухай хуулийн 10 дугаар зүйлийн 10.1 дэх хэсгийг үндэслээд саяын 7 зарчимд нийцсэн 44 хууль, тогтоол шийдвэрийн төсөл, 2 дахь заалтдаа хэлэлцүүлгийн шатад байгаа, мөн Монгол Улсын Ерөнхийлөгч, Их Хурлын гишүүд, Засгийн газраас өргөн мэдүүлчихсэн энэ тогтоолын 1 дэх заалтад зааснаас бусад хууль, Улсын Их Хурлын бус шийдвэрийн төслүүдийг хаврын ээлжит чуулганаар хэлэлцүүлэх эсэх асуудлыг тухай бүрд нь Дэгийн тухай хуулийн 10.7-д заасны дагуу шийдвэрлэж байхаар тогтоох тухай заалт, мөн түрүүн хэлсэн “Үндсэн хуульд оруулсан нэмэлт, өөрчлөлтөд хууль тогтоомжийг нийцүүлэх, түүнтэй холбогдуулан авах арга хэмжээний тухай” 20 оны 2 дугаар тогтоол, “Хууль тогтоомжийг 24 он хүртэл боловсронгуй болгох үндсэн чиглэл батлах тухай” Их Хурлын 21 оны 12 дугаар тогтоолд тусгагдсан хууль тогтоомжийн төслүүдийг Их Хуралд өргөн мэдүүлж хэлэлцүүлэхийг Засгийн газарт даалгасан заалт. Ээлжит чуулганаар хэлэлцэх асуудлын бэлтгэл

хангахыг Их Хурлын Байнгын хороод, Их Хурал дахь намын бүлгүүд, Засгийн газар, Их Хурлын Тамгын газарт даалгасан үүрэг болгосон ийм заалтуудтай тогтоолын төсөл та бүхэнд тараасан байгаа.

Тогтоолын төсөлтэй холбогдуулаад асуух гишүүн байвал нэрээ өгье. Байхгүй байна.

Уг хэлэх гишүүн байна уу? Байхгүй байна. Ингээд тогтоолынхоо төслийг маргааш чуулганы нэгдсэн хуралдаанд оруулна.

“Монгол Улсын Их Хурлын 2024 оны хаврын ээлжит чуулганаар хэлэлцэх асуудлын тухай” Улсын Их Хурлын тогтоолын төслийг чуулганы нэгдсэн хуралдаанд оруулж батлуулах нь зүйтэй гэсэн томъёоллоор санал хураалт явуулъя. Санал хураалт. Дөхөж байна.

12 гишүүн санал хураалтад оролцож, 75 хувиар тогтоолын төслийг хэлэлцүүлэх нь зүйтэй гэж үзлээ.

Нэгдсэн хуралдаанд би өөрөө танилцуулчих уу даа.

Хаврын чуулганаар хэлэлцэх асуудлын тогтоолын төслийг хэлэлцэж дууслаа. Дараагийн асуудалдаа орё.

16.43 цаг

**“Хянан шалгах түр хороо байгуулах тухай” Их Хурлын тогтоолын төслийг хэлэлцэнэ.**

Улсын Их Хурлын гишүүн Ганибал нарын 24 гишүүнээс 23 оны 11 сарын 27-ны өдөр өргөн мэдүүлсэн Монгол Улсын Их Хурлын хяналт шалгалтын тухай хуулийн 37 дугаар зүйлийн дагуу Хянан шалгах түр хороо байгуулах энэ асуудлыг хэлэлцэнэ.

Батсуурь гишүүн тогтоолын төслөө, гишүүд бол тогтоолын төслөө боловсруулаад гарын үсэг зураад бас

өргөн мэдүүлчихсэн байж байгаа. Гишүүдэд тараасан. Батсуурь гишүүн товч танилцуулга хийчихье. Батсуурь гишүүний микрофоныг өгье. Хамаагүй ээ энэ өргөн барьсан гишүүдийн аль нэг нь танилцуулчихаж болно.

**Ж.Батсуурь:** Байнгын хорооны эрхэм гишүүд ээ,

Нийтийн тээврийн парк шинэчлэлийн хүрээнд 2023 онд худалдан авсан автобусны худалдан авалтын үйл ажиллагааг Хянан шалгах түр хороо байгуулах тухай Монгол Улсын Их Хурлын тогтоолын төслийн талаар Монгол Улсын Үндсэн хуулийн 28 дугаар зүйлийн 2 дахь хэсэг хуулийн биелэлтийг хангахтай холбоотой нийтийн ашиг сонирхлыг хөндсөн тодорхой асуудлаар Улсын Их Хурлын нийт гишүүний дөрөвний нэгээс доошгүй нь хянан шалгах түр хороо байгуулах санал тавивал Улсын Их Хурал Цөөнхийн төлөөллийг оролцуулан уг хороог байгуулна гэж Монгол Улсын Их Хурлын тухай хуулийн 30 дугаар зүйлийн 30.1 дэх хэсэг, Үндсэн хуулийн 28 дугаар зүйлийн 2 дахь хэсэгт заасны дагуу хуулийн биелэлтийг хангахтай холбоотой нийтийн ашиг сонирхлыг хөндсөн тодорхой асуудлаар Улсын Их Хурлын гишүүний нийт гишүүдийн дөрөвний нэгээс доошгүй нь хянан шалгах түр хороо байгуулбал, санал тавивал цөөнхийн төлөөллийг оролцуулан Их Хурлын тогтоолоор хойшлуулиггүйгээр байгуулна гэж. Монгол Улсын Их Хурлын хяналт шалгалтын тухай хуулийн 33 дугаар зүйлийн 31.1 дэх хэсэгт, Үндсэн хуулийн 28 дугаар зүйлийн 2 дахь хэсэгт заасан хуулийн биелэлтийг хангахтай холбоотой нийтийн ашиг сонирхлыг хөндсөн тодорхой асуудлаар Улсын Их Хурлын нийт гишүүний дөрөвний нэгээс доошгүй нь Хянан шалгах түр хороо байгуулах санал тавивал цөөнхийн төлөөллийг оролцуулан Улсын Их Хурлын тогтоолоор уг хороог байгуулна гэж тус тус заасан.

Хуулийн дээрх заалтуудыг үндэслэн нийтийн ашиг сонирхлыг хөндсөн асуудал болох 2023 онд нийтийн тээврийн автобус худалдан авах ажиллагаа нь ашиг сонирхлын зөрчилтэй, хуулийг буруу хэрэглэж худалдан авах ажиллагаа зохион байгуулсан асуудлаар Хянан, шалгах түр хороо байгуулах Улсын Их Хурлын тогтоолын төслийг санаачлах шаардлага үүссэн юм.

Тухайлбал, Нийслэлийн Засаг даргын Тамгын газрын “Тэнүүн-Огоо” ХХК-тай гэрээ байгуулан худалдан авсан зорчигч тээврийн автобусыг үндэсний аюулгүй байдлыг хангахтай холбогдох тусгай зориулалтын тоног төхөөрөмж, багаж хэрэгсэл, техник байгууламж, ажил үйлчилгээ болон галт зэвсэгтэй холбож Төрийн болон орон нутгийн өмчийн хөрөнгөөр бараа, ажил, үйлчилгээ худалдан авах тухай хуулийг мөрдөөгүй нь хуулийн зөрчил болсон гэж хэлэх үндэслэлтэй юм.

Төрийн өмчийн хөрөнгөөр бараа, ажил, үйлчилгээ худалдан авах хууль тогтоомжийг хэрэгжүүлэхгүй байгаа байдал цар тахлын үеэс газар авч өнөөдрийг хүртэл үргэлжилж, төсвийн хөрөнгийг зориулалт бусаар үр ашиггүй зарцуулж байгаа байдалд хяналт тавих нь зүйтэй гэж үзэн Улсын Их Хурал дахь Ардчилсан намын бүлгээс Улсын Их Хурлын гишүүн Ганибалаар ахлуулан ажлын хэсэг байгуулсан байна.

Энэхүү ажлын хэсэг нийтийн тээврийн парк шинэчлэлийн хүрээнд автобус худалдан авах ажиллагаа нь Монгол Улсын хууль тогтоомж зөрчсөн эсэх, худалдан авах ажиллагааны явцад авлига, албан тушаалын болон төсвийн хөрөнгийг үр ашиггүй зарцуулсан гэм буруутай үйлдлүүд байгаа эсэх, үндэсний аюулгүй байдлыг хангахтай хэрхэн холбогдсон, холбогдох үндэслэлтэй эсэх, худалдан авалттай холбоотой нотлох баримтыг цуглуулах, шинжлэн судлах, нээлттэй сонсгол зохион байгуулах үүрэг бүхий Хянан шалгах түр хороо байгуулах

ажиллах нь үр нөлөөтэй гэж үзэж Улсын Их Хурлын тогтоолын төслийг санаачлан боловсруулан өргөн мэдүүлж байна.

Тогтоолын төсөл батлагдсанаар дараах эерэг үр дүн гарна гэж дүгнэж байна. Үүнд:

1.Төрийн байгууллагууд шат шатдаа төсвийн хөрөнгийг үр ашиггүй зарцуулдаг байдал арилж, авлига албан тушаал, ашиг сонирхлын зөрчлийг дагасан таслан зогсооход эерэг нөлөө үзүүлнэ.

2.Төрийн бүх шатын худалдан авах ажиллагааны ил тод, нээлттэй байдал Шилэн дансны хуулийн хэрэгжилтийг сайжруулах үндэс болно.

3.Нийтийн тээврийн парк шинэчлэлтийн хүрээнд 2023 онд хийсэн автобус худалдан авах ажиллагаа гэмт хэргийн шинжтэй эсэх, хууль, тогтоомж зөрчсөн эсэх, төсвийн хөрөнгийг үр ашиггүй зарцуулсан эсэх тодорхой болох юм.

4.Хувийн хэвшлийг чөлөөт өрсөлдөөнийг дэмжихэд эерэг нөлөө үзүүлнэ гэж үзэж байна.

Эрхэм гишүүд ээ,

Та бүхэн хэлэлцэн шийдвэрлэж өгөхийг хүсье.

**Н.Энхболд:** Батсуурь гишүүнд баярлалаа. Сая нэр бүхий гишүүд энэ асуудлыг шалгах түр хороо байгуулах талаар саналаа ирүүлсэн. Үүний тухай хэлэлцэж байна. Энэ асуудлыг хэлэлцэж байгаатай холбогдуулаад бас Улаанбаатар хотын Засаг даргаар ажиллаж байсан Сумъяабазараас албан бичиг ирсэн. Би үүнийг танилцуулчихъя. Хүсэлт гаргах тухай,

Монгол Улсын Их Хурлын 2020 оны 24 дүгээр тогтоолоор баталсан Засгийн газрын 2020-24 оны үйл

ажиллагааны хөтөлбөрийн 6.1.5-д нийтийн тээврийн үйлчилгээнд зорчигчдын ая тухтай нөхцөл, зорчих нөхцөлийг хангасан ухаалаг эко цахилгаан хөдөлгүүрт дам болон давхар автобус, цахилгаан соронзон болон дүүжин замын тээврийн хэрэгслийн хэрэглээнд үе шаттайгаар хэрэгслийг хэрэглээнд үе шаттайгаар нэвтрүүлнэ гэж, 6.1.6-д Улаанбаатар хотын замын хөдөлгөөний нягтралыг сарниулж, ачааллыг тэнцвэржүүлсэн, тээврийн эрэлтэд нийцсэн авто замын сүлжээг бий болгож, түгжрэлийг бууруулна гэж тус тус заасан.

Түүнчлэн нийслэл Улаанбаатар хотын тулгамдсан асуудлын нэг болох нийтийн тээврийн чанар, хүртээмжийг нэмэгдүүлэх арга хэмжээг цаг алдалгүй иуурхай шийдвэрлэх хэрэгцээ шаардлага үүссэн юм. Энэ хүрээнд Монгол Улсын 2023 оны Төсвийн тухай хуульд заасан Монгол Улсын сайд Нийслэл Улаанбаатар хотын авто замын түгжрэлийг буур болох Үндэсний хорооны даргын захиран зарцуулах нийтийн тээврийн автобус худалдан авах төсөл, арга хэмжээний төслийг Нийслэлийн Засаг дарга бөгөөд Улаанбаатар хотын захирагчид эрх шилжүүлсний дагуу уг төсөл, арга хэмжээг Нийслэлийн Худалдан авах ажиллагааны газар зохион байгуулж ажилласан. Тус худалдан авах ажиллагааны явцад хууль зөрчсөн байж болзошгүй талаарх баримт мэдээлэл олон нийтэд ил болж, уг асуудлаар хууль хяналтын байгууллагын хянан шийдвэрлэх ажиллагаа явагдаж байгаа энэ цаг үед ногоон автобус гэх худалдан авах ажиллагаатай холбоотойгоор хэвлэл мэдээллийн хэрэгслээр бодит бус мэдээлэл тараагдаж байгаа нь иргэдийн дунд бухимдал үүсгэж байна.

Энэхүү худалдан авах ажиллагаатай холбоотойгоор миний бие ёс зүйн хариуцлага хүлээж, өөрийн хүсэлтээр албан тушаалаасаа чөлөөлөгдсөн бөгөөд нийслэл хотод хэрэгжүүлж ирсэн нийтийн тээврийн

шинэчлэлтэй холбоотой худалдан авах ажиллагаа авах ажиллагааны талаарх үнэн, зөв, бодитой мэдээллийг олон нийтэд өгч, иргэдийн мэдэх эрхийг хангах шаардлагатай гэж үзэж байна.

Иймд Монгол Улсын Нийтийн сонсгол тухай, Монгол Улсын Их Хурлын хяналт шалгалтын тухай хуульд тус тус заасны дагуу нийтийн сонсгол зохион байгуулж өгөхийг хүсье гэсэн ийм бичиг бас ирсэн юм.

Энэ зүйлүүд энэ хянан шалгах түр хорооны хийх ажлын хүрээнд давхар багтаад явж байгаа гэдгийг би хэлчихье. Тийм. Ингээд тогтоолын төслөө ерөнхийд энэ бараг хүрээндээ дотор нь багтаж байгаа юм даа тийм. Энэ хүсэлтийн дагуу тогтоолын төсөл боловсруулсан. Тогтоолын төслөө танилцуулчихъя.

Монгол Улсын Их Хурлын тогтоол, “Хянан шалгах түр хороо байгуулах тухай” Нийтийн тээврийн парк шинэчлэлийн хүрээнд 2023 онд хийсэн автобус худалдан авах ажиллагааг төрийн болон албан нууцад хамааруулан гэрээ шууд байгуулсан үндсэн шалтгаан нөхцөлийг шалгах шаардлагыг харгалзан Монгол Улсын Үндсэн хуулийн 28 дугаар зүйлийн 2 дахь хэсэг, Улсын Их Хурлын тухай хуулийн 30 дугаар зүйлийн 30.1 дэх хэсэг, Монгол Улсын Их Хурлын хяналт шалгалтын тухай хуулийн 33.1 дэх хэсэг, 34 дүгээр зүйлийн 34.2, 34.3 дахь хэсгийг үндэслэн Монгол Улсын Их Хурлаас ТОГТООХ нь:

Монгол Улсын Их Хурлын хянан шалгах түр хорооны тусгай шалгалтын сэдвийг нийслэлийн нийтийн тээврийн чанар, хүртээмжийг нэмэгдүүлэх, парк шинэчлэх шаардлагын дагуу худалдан авсан автобусны худалдан авах ажиллагаанд хяналт шалгалт хийхээр тогтоосугай.

Улсын Их Хурлын Хянан шалгах түр хорооны тусгай шалгалтын хүрээ хязгаарыг доор дурдсанаар тогтоосугай.

Худалдан авах үйл ажиллагааг шуурхай зохион байгуулсан үндэслэл шалтгаан.

2.Төрийн нууцад хамааруулсан шалтгаан, Төрийн болон албаны нууцаас гаргах шаардлагатай байсан эсэх.

3.Төрийн болон орон нутгийн өмчийн хөрөнгөөр бараа, ажил, үйлчилгээ худалдан авах тухай хуулийн 35 дугаар зүйлд заасан гэрээ шууд байгуулах аргаар хийсэн нь үндэслэлтэй эсэх.

4.Нээлттэй сонсгол зохион байгуулж, иргэд, олон нийтийг үнэн, зөв мэдээллээр хангах.

3.Улсын Их Хурлын Хянан шалгах түр хороог дараах бүрэлдэхүүнтэйгээр байгуулсугай.

Олонхыг төлөөлөн П.Анужин, Д.Батлут, Ж.Бат-Эрдэнэ, Х.Ганхуяг, Ц.Даваасүрэн, Г.Тэмүүлэн, Ж.Чинбүрэн, цөөнхийг төлөөлөн Ж.Батсуурь, Н.Ганибал, С.Одонтуяа, Т.Доржханд.

4.Энэ тогтоол, энэ ер нь энэ үг нь илүүдсэн юм шиг байгаа юм. Тусгай шалгалтын тайлан, санал, дүгнэлтийг Улсын Их Хурлын хяналт шалгалтын тухай хуулийн 33 дугаар зүйлийн 33.8-д заасан хугацаанд Улсын Их Хуралд танилцуулахыг Түр хороонд даалгасугай.

5.Энэ тогтоолыг баталсан өдрөөс эхлэн дагаж мөрдсүгэй гэсэн төсөл байна.

Хуулиараа 19 гишүүн санал гаргахад Байнгын хороо байгуулах ёстой. Түр хороо байгуулах ёстой. Түр хороонд оролцох гишүүдийн гуравны нэгээс доошгүй нь цөөнхийн төлөөлөл байна гэсэн ийм заалттай. Үүний дагуу Улсын Их Хурал дахь намын бүлгүүд, Улсын Их Хурал дахь намын төлөөллүүдээс саналыг нь аваад дээрх нэрсийг санал болгож оруулж байгаа гэдгийг бас давхар хэлчихье.

Төсөлтэй холбогдуулаад асуух гишүүн байна уу? Асууна, үг хэлнэ. Хамт шүү. Мөнхцэцэг гишүүн, Батсуурь гишүүн.

**Ц.Мөнхцэцэг:** Тэгэхээр энэ нийтийн тээврийн парк шинэчлэлийн асуудал бол бас нийтийн эрх ашгийг хөндсөн, мөн тодорхой албан тушаалтнууд нийтийн сайн, сайхны төлөө хөрөнгийг эрх мэдлийн эсвэл өөртөө баялаг хуримтлуулах нэрээр идэж уусан авлигын нэг том хэргийн ийм сүлжээ байна.

Тэгэхээр манай энэ тогтоолын Хянан шалгах түр хороонд ерөөсөө 23 онд хийсэн автобус худалдан авалт гэдгээр хязгаарлагдаад байна. Гэтэл бидэнд байгаа мэдээллээр мөн хотын дарга Нямбаатар сайдын бас хэвлэлд өгсөн мэдээллээс харахад ерөнхийдөө парк шинэчлэлийн асуудал асар их булхай, будилаантай явж иржээ. Ер нь 2009 оноос хойших нийтийн тээврийн парк шинэчлэлийн асуудлууд, тендер, худалдан авалтууд ямагт будилаан бүхий, эсвэл тодорхой авлигын эх үүсвэр бүхий явж ирсэн байдаг.

Тухайлбал, 2009 оноос хойш нийтдээ 10 удаа худалдан авалт хийхэд энэ бараг бүх худалдан авалтууд шууд гэрээгээр буюу огт тендергүй явж ирсэн байгаа. Ингэхдээ маш цөөхөн тодорхой хэдэн компаниудад давуу тал олгосон байх магадлалтай. Жишээлбэл, 2009 онд 400 автобусыг улсын төсвийн хөрөнгөөр худалдаж авсан байдаг. Энэ үед бол Зам тээврийн сайдаар тухайн үед Баттулга, Сангийн сайдаар Баярцогт, хотын дарга Мөнхбаяр нар ажиллаж байсан байна. Мөн л тендергүй шууд худалдан авалтаар орж ирсэн байдаг.

Тэгэхээр энэ хугацаанд энэ Нийслэлийн өмчийн харилцааны газраас энэ яг энэ тендертэй холбоотойгоор бас хохирол учирсан, дээрх хэмжээний мөнгөн хохирол учирсан гэдгийг хэлээд байдаг. Нийтдээ бараг 35.6 тэр тэрбум

төгрөгийн хохирол учирсан гэсэн мэдээлэл байгаа. Мөн 2015 оноос хойш 500 гаруй автобусны парк шинэчлэл хийсэн байгаа. 2023 оноос өмнө хүртэл.

Гэтэл эдгээрийн парк шинэчлэл хийсэн автобуснуудын нэлээд нь нийтийн тээврийн үйлчилгээндээ яваагүй, өөрөөр хэлбэл гэрээгээр хүлээсэн хугацаандаа яваагүй актлагдсан байдаг. Дандаа чанарын шаардлага хангаагүй автобус оруулж ирсэн.

Өөрөөр хэлбэл, нийтийн тээврийн салбарт монопол тогтоочихсон хэдхэн компаниуд тендерт ордог. Тэгээд тухайн компаниуд нийслэлийн төсвөөс 300 орчим тэрбум төгрөгийн татаас жил бүр авч байгаа гэдэг ийм мэдээлэл байгаа. Ингэхдээ энэ татаас авахдаа гүйцэтгэл дээр үндэслэхгүй, зөвхөн хэн хэдэн хүнд үйлчилсэн гэдэг нь анхаарал хандуулдаг вэ гэдгийг бол хотын дарга Нямбаатар мэдэгдэж байсан.

Тийм учраас нийслэлийн тээврийн асуудлаар хянан шалгах түр хороо байгуулах гэж байгаа бол бид нар зөвхөн 2020 он гэхгүйгээр 2009 байна уу, түүнээс өмнөх жилүүдийг мөн бүгдийг нь шалгах ёстой гэдэг ийм санал хэлмээр байна. Ингэж байж бид нар энэ салбар дахь нийтийн эрх ашгийг хөндсөн тодорхой асуудлаарх будилаан, булхайг ил гаргаж чадна. Энэ манай Улсын Их Хурлын хяналт шалгалтын нэг гол асуудал байгаа.

Тэгэхээр энэ саналыг хэлмээр байна. Энэ дээр хариулт авъя. Ер нь бол манай олон нийт мэдэж байгаа. Ийм хэвлэл мэдээлэл ч их гарлаа. Нийтийн тээврийн салбарт монопол тогтоочихсон цөвхөн хэдэн аж ахуйн нэгжүүдийн энэ булхай, луйвар бол өнөөдрийн энэ Улаанбаатар хотын замын түгжрэл, нийтийн тээвэр хүртээмжгүй байдлын гол буруутан байгаа.

Тийм учраас бид нар өмнө нь хэлсэн энэ Хөгжлийн банкны болон

Нүүрсний Хянан шалгах түр хороотой адил хэмжээний энэ нийтийн тээврийн асуудлыг өргөн хүрээнд буюу урт хугацаанд шалгах шаардлага байгаад байна. Энэ асуултад хариулт авъя.

**Н.Энхболд:** Юу ч гэсэн хууль санаачлагчийн зүгээс саналаа хэлчихье. Тэгээд хэдүүлээ Байнгын хороогоороо ярьж байгаад л шийднэ дээ. Тийм. Батсуурь гишүүний микрофоныг өгье.

**Ж.Батсуурь:** Нийгэмд бухимдал үүсгэж байгаа маш олон зүйлүүд бий л дээ. Нөгөө хүрээний бузрыг ухвал далай далай гэдэг шиг. Энэ тогтоол дээр 23 он гэж жишээлэх юм бол бид нар Нүүрсний сонсгол, Хөгжлийн банкны сонсгол юу юу ч билээ аягүй олон зүйл, маш олон Түр хороонууд байгуулагдчихсан. Аливаа зүйл хамрах хүрээ нь хязгаарлагдмал байвал оновчтой шийдвэр гарна гэж ингэж үзэж байгаа. Тэгээд ч энэ ногоон автобусны асуудал бол Монголын ард түмэн ёстой бүгдээрээ нүдээрээ үзэж, гараараа барьсан ийм бодит зүйл байгаа. Үүнийг аливаа бусад зүйлтэй хольж, хяналт шалгалтын үр дүнг бусдад нялзаах, эсвэл бусадтай холих, нөгөө том Тавантолгой ярингуут л жижиг талынхаа Тавантолгой гаргаад ирдэг шиг ингэж хяналт шалгалтыг хиймээргүй байгаа юм.

Хэрвээ хийе гэвэл танд ч гэсэн эрх нь байгаа байх. Ахиад тэр хэдэн оноос юугаа шалгуулмаар байгаа юм тэрийгээ 19 ба түүнээс дээш гишүүдээр гарын үсэг зуруулаад ямар ч зүйлийг нотой, ноцтой байна, хууль зөрчсөн байна, авлига, гэмт хэргийн шинжтэй байна, ард түмний хөрөнгө мөнгийг шавшигдуулсан байна гэж үзэж байгаа. Шалгуулах бүрэн боломж нь байж байгаа. Энэ угаасаа үүнийг санаачилсан хүмүүсийн гол, би сая тэр товч танилцуулга дээр уншсан. Тэгэхлээр энэ дээр яг оновчтой хүрээг хамрах байдлууд оруулж байгаа учраас үүнийг заавал ингэж бусдад нялзааж яахгүй байх ёстой байх л гэсэн ийм байдлаар хариулт өгч байна.

**Н.Энхболд:** Яах ёстой юм? Мөнхцэцэг гишүүн ээ ямар саналтай байна? Ер нь ганц 23 оных ч биш, Чи чинь юун дотроо байгаа билүү? Гарын үсэг зурсан гишүүн дотор байгаа юу байгаа юу?

Санал хураана. Тогтоолынхоо төслөөр санал хураая. Тийм. Бас ийм юм яг үнэнийг хэлэхэд энэ жишээ нь Түр хороо байгуулах гишүүд өөрсдийнхөө тэр цар хүрээгээ ийм хэмжээнд гээд оруулаад ирсэн бол дараа нь тэрийг өөрчлөх тухай асуудал нь бүгдээрээ санал нэгтэй болж байж өөрчилдөг тийм хуулийн заалт бас байгаа.

Тэгэхээр яг одоо үүгээр тусгайлан аваад явахад хэцүү. Ерөнхийдөө, та нар бас тэр бүхнийг анхаарна биз. Бид нар бол анх оруулж ирсэн дотроос зүгээр сэдвийг нь нийслэлийн нийтийн тээврийн чанар, хүртээмжийг нэмэгдүүлэх, парк шинэчлэх шаардлага гэж юмнууд оруулсан байгаа. Тэр юмнууд нь тэртээ тэргүй шалгалтын явцад та нар дахиад үзэх юм гарвал үргэлжлүүлээд үзэж болох учраас, тийм учраас би уншиж танилцуулсан төслийнхөө дагуу санал хураалгая.

Цогтоо, үгүй ээ үгүй миний асуудалд орох хамаагүй л дээ. Би түрүүн уншсан тогтоолыг тийм ээ. Яаж уншсан нь юунд байж байгаа, юман дотор, протоколд тусчихсан байгаа байх.

Ингээд Түр хороо байгуулах тухай Улсын Их Хурлын тогтоолыг тогтоолын төслийг дэмжье гэсэн томъёоллоор санал хураалт явуулна. Их Хурал дээр асуудал яаж яригдахыг Их Хурал өөрөө мэдэх асуудал шүү. Гишүүд ээ анхаараарай. Миний уншсанаар шүү. Протокол харахад яаж уншсан нь харагдана. Тэн дээр энэ нөхөр. Санал хураалт.

9 гишүүн дэмжиж, санал 75 хувиар дэмжигдэж байна. Хэн унших вэ? Мөнхцэцэг гишүүн унших уу? Дэмжээгүй

юм уу? Яах вэ энэ үндсэн хэрэг. Айн эмэгтэй хүнээр уншуулчихъя тэгэх үү? Адьясүрэн зурсан юм уу? Адьясүрэн гишүүн. Дараагийн асуудалд оръё. Одоо хоёрхон асуудал байгаа.

17.07 цаг

**Ажлын хэсгийн бүрэлдэхүүнд өөрчлөлт оруулах тухай нэг асуудал байгаа.**

Энэ урьд нь гарсан тогтоол байгаа юм. Тэр нь юу гэсэн тогтоол байсан гэхээр энэ Монгол Улсын засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгжийг өөрчлөх асуудлаар иргэдийн санал авах журам, иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын Төлөөлөгчийг сонгогчдын саналаар эргүүлэн татах журам, иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын зөвлөлийн ажиллах журам батлах тухай тогтоолын төслүүдийг Их Хурлын Байнгын хорооны болоод чуулганы нэгдсэн хуралдаанаар хэлэлцүүлэх, бэлтгэл хангах үүрэгтэй тийм ажлын хэсэг байгуулаад ахлагчаар нь Ганбаатар гишүүнийг томилсон байсан юм. Асуудлууд бол хэвээр байгаа. Ганцхан Ганбаатар гишүүн сайд болоод явсан учраас Байнгын хорооны бүрэлдэхүүнээс чөлөөлөөд, ажлын хэсгийн ахлагчаар нь Ганболд гишүүнийг томилсугай гэсэн ийм Байнгын хорооны тогтоол байгаа.

Үүнтэй холбоотой асуух үг хэлэх гишүүн байна уу? Тэгвэл энэ тогтоолын төслийг дэмжье гэсэн санал хураалт явуулъя. Тийм, тийм юм байгаа. Тийм.

12-оос 9 дэмжиж 75 хувиар тогтоол батлагдлаа.

Дараагийн асуудалдаа оръё.

17.08 цаг

**Ажлын хэсэг байгуулах тухай тогтоол байна.**



Монгол Улсын Их Хурлын Байнгын хорооны тогтоол “Ажлын хэсэг байгуулах тухай”

Монгол Улсын Их Хурлын тухай хуулийн 23 дугаар зүйлийн 23.2.14 дүгээр заалтыг үндэслэн Төрийн байгуулалтын байнгын хорооноос ТОГТООХ нь:

1.Олон нийтийн радио, телевизийн тухай хуулийн хэрэгжилтийн үр дагаварт хийсэн үнэлгээний тайлантай танилцаж шаардлагатай бол хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах хуулийн төслийг боловсруулах үүрэг бүхий ажлын хэсгийг дараах бүрэлдэхүүнтэй байгуулсугай.

Ажлын хэсгийн ахлагч М.Оюунчимэг Улсын Их Хурлын гишүүн, ажлын хэсгийн гишүүн Б.Баттөмөр зөвшилцсөнөөр, энэ өөр Байнгын хорооноос орж байгаа учраас өөртэй нь, Байнгын хороотой нь зөвшилцөөд оруулж байгаа Улсын Их Хурлын гишүүн, Ёс зүй, сахилга, хариуцлагын байнгын хорооны дарга, Ж.Батсуурь Улсын Их Хурлын гишүүн, Г.Ганболд Улсын Их Хурлын гишүүн.

2.Ажлын хэсэгт мэргэжил арга зүйн туслалцаа үзүүлэх холбогдох байгууллагын албан тушаалтныг тухай бүр татан оролцуулахыг ажлын хэсэг Оюунчимэгт зөвшөөрсүгэй.

3.Энэ тогтоол батлагдсантай холбогдуулан Төрийн байгуулалтын байнгын хорооны 22 оны 4 сарын 20-ны өдрийн “0” дугаар тогтоолыг хүчингүй болсонд тооцсугай гэсэн ийм тогтоолын төсөл байна.

Урьд нь бид нар бас Байнгын хорооноос чиглэл өгөөд, Улсын Их Хурлын Тамгын газрын Хяналт шалгалт, үнэлгээний газраар Олон нийтийн радио, телевизийн тухай хуулийн хэрэгжилтийн үр дагаварт хийсэн үнэлгээний тайлан гэж ийм том тайлан гарсан байгаа. Энэ тайлантай Оюунчимэг дарга ажлын хэсгийн гишүүд танилцаад яаралтай

болбол маргааш, нөгөөдөр, чуулган завсарлахаас өмнө Олон нийтийн радио, телевиз дээр радиогийнхонтой уулзаад Үндэсний зөвлөлийн гишүүнтэй, шаардлагатай албан тушаалтнуудтай хамт олны төлөөллөөс уулзаад, саналаа боловсруулаад яаралтай оруулж ирэх ийм чиглэл өгч байгаа шүү.

Энэ тогтоолтой холбогдуулаад асуух, үг хэлэх гишүүн байна уу? Хамт юм. Байхгүй байна.

Тогтоолын төслөө баталъя гэсэн санал хураалт явуулъя. Санал хураалт. Одоо Байнгын хорооноос зарим хүнийг чөлөө өгсөн танд тийм.

12 гишүүн оролцож, 9 гишүүн дэмжиж, 63.2 хувиар Байнгын хорооны тогтоол батлагдлаа.

Өнөөдрийн Байнгын хорооны хуралдаанаар хэлэлцэх асуудал дууслаа. Гишүүддээ баярлалаа.

Маргааш чуулган хуралдахаас өмнө 9.30-аас шүү. Ерөөсөө ганцхан юм байгаа. 9.30-аас Байнгын хорооны хуралдаантай шүү.

Өнөөдрийн хуралдаан дууслаа. Баярлалаа гишүүд ээ.

17.11 цаг

ДУУНЫ БИЧЛЭГЭЭС ХУРАЛДААНЫ  
ДЭЛГЭРЭНГҮЙ ТЭМДЭГЛЭЛ  
БУУЛГАЖ ХЯНАСАН:  
ШИНЖЭЭЧ Д.ОТГОНДЭЛГЭР

